

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар

2022 оны жилийн эцэс,

Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ
МУ-ын хууль				
1	Ойн тухай /Шинэчилсэн найруулга/ 2012-05-17 Дугаар 2022.06.03	39.7. Ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, сум, нийслэл, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана.	Аймгийн хэмжээнд хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажилд нийт 13 ш үлээгч аппарат, БХНСАХЗ болон төсөл хөтөлбөрөөс нийт 19.030,800 төгрөг санхүүжилт гарснаас багаж хэрэглэлд- 13.370.000 төгрөг, урьдчилан сэргийлэх ажилд - 5660.800 төгрөг зарцуулагдсан байна. Тухайлбал: 1/."Дорнод Монголын Хуурай Хээрийн Тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлыг хамгаалах" төслөөс Сүхбаатар, Мөнххаан, Түмэнцогт сумдад түймрээс хамгаалах багаж хэрэгсэл болох үлээгч аппарат -9 ш, хамгаалалтын хувцас хэрэгсэл -30 ш / нүдний шил, бээлий, түймэр цуравдагч, усны сав / зэрэг 11,970.000 төгрөгийн багаж хэрэглэлийн дэмжлэг олгосон. 2. БОАЖГ-аас Дарьганга суманд 4 ш үлээгч аппарат 1400000 төгрөгөөр, аймгийн ОБГ-тай хамтран "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх " ажлыг Мөнххаан, Түмэнцогт, Сүхбаатар, Асгат, Эрдэнэцагаан, Дарьганга нийт 6 сумын 350 орчим өрхөд 6 төрлийн 2400 ш гарын авлагыг тарааж 1400 иргэнээс гарын үсгийн баталгаа авсан. 3. Түймэр гарах эрсдэлтэй 6 сумдын ард иргэдэд Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх Мессеж мэдээг 9 удаа хүргэн давхардсан тоогоор 25983 малчин өрхөд хүргэсэн. Асгат сумын 110, Дарьганга 194, Баруун-Урт 764, Сүхбаатар 835, Түмэнцогт 212, Эрдэнэцагаан 616, Мөнххаан 156 хөдөөгийн иргэдийн гар утсанд мессежээр анхааруулга мэдээг хүргэж ажилласан. Орон нутгийн BBS телевизэд хээрийн түймрээс хамгаалах, сэрэмж 2 төрлийн шторк, 1 урсдаг зарыг явуулсан. Дээрх ажлыг УЦУОШТөв, Скайтель ХХК -тай гэрээ байгуулж ажилласан. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх Засгийн газрын 106 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасны дагуу төлөвлөн арга хэмжээний зардлыг сумдын төсөвт тусган ажиллаж байна. Хавсралт : 2 файл	100%

2	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	18.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 сарын 16-ны өдрийн 01 тоот тогтоолоор Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг баталсан ба хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг 2021 оны А/12 тоот захирамжаар байгуулж, ажлын хэсэг анхдугаар хуралдаанаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний саналыг хэлэлцсэн. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар туршилт хэлбэрээр Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр 4 дэх жилдээ хэрэгжиж байна. Аймгийн хэмжээнд 1500 өрхөөс түүврийн аргаар судалгаа авч үүнээс 270 өрхийн 1262 иргэн гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрт хамрагдаж, нийгмийн халамжийн үйлчилгээ, эрх зүйн үйлчилгээ, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ болон бусад шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээг үзүүлж ажиллаж байна. Мөн "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ"-ний хүрээнд 8 модуль хичээлийг 5869 иргэдэд цахимаар, гэрээр айлчлах аянаар дамжуулан 2816 өрхөд зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 28 сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор 16318 иргэнийг хамруулсан байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Аймгийн Цагдаагийн газрын дэргэд "Үжин төв"-ийн харьяа хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор түр хамгаалах байр байгуулагдаж 2022 оны 5 сард ашиглалтад орсон. Одоогийн байдлаар 6 албан хаагчтай, түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд 1-66 хоногийн хугацаанд 24 хүүхэд, 29 насанд хүрэгчид түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлсэн байна. Хавсралт : 1 файл	100%
---	---	---	--	------

3		18.1.2.. Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх зардалд 2022, 2023 онд тус бүр 90,0 сая төгрөгийг АИТХ-аар батлуулан хэрэгжүүлж байна. Хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, хүүхэд хамгаалалд 13 сум нийт 16,100,000 төгрөгийн төсөв батлагдсан. Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд төрийн албан хаагчдын үүрэг, оролцоо" сэдэвт сургалтыг 22 хамтарсан багийн 150 гаруй гишүүдэд зохион байгуулсан. Тус сургалтад аймгийн Засаг даргын тамгын газраас 2,8 сая төгрөг зарцуулсан. "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ"-гээр 13 сумын 22 хамтарсан баг, 102 байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл, 40 хүүхэд хамгааллын багт ажлын байранд чадавхжуулах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 сарын 16-ны өдрийн 01 тоот тогтоолоор "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх" дэд хөтөлбөрийг баталсан ба хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хэсэг 2022 оны А/12 тоот захирамжаар байгуулагдсан. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд орон нутгаас 20 сая төгрөг баталсан. Хавсралт : 2 зураг	100%
4		18.1.3.. Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Ази номхон далайн бүс нутгийн цогцлоох Японы сангийн буцалтгүй тусламжаар Хууль зүй дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банкны хамтарсан төслийн дагуу 253.6 сая төгрөгийн санхүүжилтээр нэг удаа 8 хүн хүлээн авах боломжтой, 177 мкв талбай бүхий түр хамгаалах байр байгуулагдаж 2022 оны 5 сард ашиглалтад орсон. Одоогийн байдлаар 6 албан хаагчтай, түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд 1-66 хоногийн хугацаанд 24 хүүхэд, 29 насанд хүрэгчид түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлсэн байна. Хавсралт : 3 зураг	100%

5		19.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах 48 сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор 16218 иргэнийг хамруулсан. Гэр бүлийн боловсрол олгох ажлын хүрээнд 16218 иргэнд үйлчилгээ үзүүлж, “Эцэг эхийн зөвлөл”-өөр дамжуулан 102 зөвлөл, 326 албан хаагчид зөвлөгөө мэдээллийг өгч ажиллалаа. "ХҮҮХДИЙГ ЗОДОЖ ШИЙТГЭХИЙГ ТАСЛАН ЗОГСООХ ДЭЛХИЙН ӨДӨР"- ийг тохиолдуулан "Эерэг хүмүүжил - Эерэг нийгэм" нэвтрүүлэг бэлтгэж, байгууллагын цахим хаяг болон орон нутгийн телевизээр олон нийтэд хүргэсэн. Олон Улсын Гэр бүлийн өдрийг тохиолдуулан "Гэр бүлийн үнэ цэнэ" нөлөөллийн арга хэмжээг Баруун - Урт сумын ЗДТГ-тай хамтран 9 багийн төлөөлөл 9 гэр бүлийн 18 иргэнийг хамруулсан уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцогчдоос уриалга гаргаж, уриалгыг олон нийтэд түгээн ажилласан. Гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр 9 модуль хичээлийг байгууллагын цахим хаяг болон орон нутгийн телевиз олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэж ажилласан. Гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр нийт 13 удаагийн постер, зөвлөмж зөвлөгөө, мэдээллийг олон нийтэд хүргэсэн. Цагдаагийн газарт гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж түр саатуулагдаж байгаа иргэдэд "Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалт"- зохион байгуулж нийт 103 иргэнийг хамрууллаа. Хавсралт : 2 зураг	100%
---	--	--	---	------

6		19.1.2.. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Сүхбаатар аймгийн хэмжээнд 22 хамтарсан баг хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар хамтарсан багийн үйлчилгээнд 145 кейс хүлээн авч 128 буюу 88 хувийг шийдвэрлээд байна. Одоогоор 17 кейс үйлчилгээний шатандаа ажиллагаанд байна 22 хамтарсан багт 28 удаагийн “Кейс конференци” зохион байгуулж, практикт суурилсан кейсийн хариу үйлчилгээ үзүүлэх арга зүйгээр хангаж, 145 кейст үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс 44 кейс ХТУ 108 дуудлага, 91 кейс холбон зуучлах, 10 кейс илрүүлгийн хариу үйлчилгээ байна. Нийт хариу үйлчилгээний 78% -г НАМС мэдээллийн санд бүртгэн ажиллаж байна. Кейсийн хариу үйлчилгээг НАМС мэдээллийн санд бүртгэх ажил явагдаж байна. Хамтарсан багийн нарийн бичиг, сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүдийн “Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд төрийн албан хаагчдын үүрэг, оролцоо, хариуцлага” үүрэг хүлээгчдийг чадавхжуулах сургалтыг "Үжин" төрийн бус байгууллагатай хамтран сургалт зохион байгуулж, сургалтад 22 хамтарсан багийн 150 гаруй гишүүдэд зохион байгуулсан. Тайлант хугацаанд Хамтарсан багийн гишүүдийг 100 хувь чадавхжуулах танхимын болон цахим сургалтад хамруулаад байна. "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ"-гээр 13 сумын 22 хамтарсан баг, 102 байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл, 40 хүүхэд хамгааллын багт ажлын байранд чадавхжуулах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Олон талт Үндэсний чуулганд хамтарсан баг болон холбогдох салбараас 17 албан хаагч оролцсон. Хавсралт : 3 зураг	100%
---	--	--	--	------

7	19.1.3.. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр тогтоолоор "Түр хамгаалах байрны " харьяалал тогтоох тухай тогтоол гарч аймгийн цагдаагийн газрын харьяанд үйл ажиллагаагаа явуулахаар шийдвэрлэсэн. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2022 онд түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийг байгуулан орон нутгаас урсгал зардлыг шийдвэрлэн тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Одоогийн байдлаар 6 албан хаагчтай, түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.	100%
8	19.1.4.. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 сарын 16-ны өдрийн 01 тоот тогтоолоор Гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг баталсан ба хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг 2021 оны 05 сарын 20-ны өдрийн А/12 тоот захирамжаар байгуулж, ажлын хэсэг анхдугаар хуралдаанаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний саналыг хэлэлцсэн. Төслийн хэрэгжилтийн хүрээнд орон нутгаас 20 сая төгрөг батлагдсан. Хавсралт : 3 зураг	100%

9		19.1.5.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүр, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь 2022 оны төсөвт хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийхэд 6000,0 мянган төгрөг, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд 22 000,0 мянган төгрөг, нийт 28000,0 мянган төгрөгийг батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд гүйцэтгэл 100 хувьтай байна. Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 сарын 16-ны өдрийн 01 тоот тогтоолоор Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг баталсан ба хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг 2021 оны 05 сарын 20-ны өдрийн А/12 тоот захирамжаар байгуулж, ажлын хэсэг анхдугаар хуралдаанаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний саналыг хэлэлцсэн. Хохирогч хамгаалах "Түр хамгаалах байр"ны үйл ажиллагааны зардалд аймаг, орон нутгийн төсөвт 90 сая төгрөг баталсан байна. Хавсралт нийт : 4 Файл : 1 Зураг : 3	100%
---	--	--	--	------

10		19.1.6.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх "Зөвлөгөө өгөх " өрөө байгууллагын дэргэд ажиллаж байна. 2022 оны байдлаар 259 иргэнд ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө үйлчилгээнд хамруулсан байна. Зөвлөгөө өгөх өрөөгөөр дамжуулан 156 насанд хүрэгч, 103 хүүхдэд сэтгэлзүйн тест оношилгоо хийж, сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөг үе шаттайгаар зохион байгуулсан. Тус байгууллагын сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудыг шаардлагатай компьютер, принтер, сканер, ширээ сандал болон зөвлөгөө өгөхөд шаардлагатай бичгийн хэргийн зардал бусад хэрэгслээр ханган тогтвортой ажиллуулах нөхцөл боломжийг бүрдүүлээд байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл, цагдаагийн газраас холбон зуучлах хуудсаар 95 кейс ирүүлснийг харьяа хамтарсан багт шилжүүлэн, хамтарсан багийн үйлчилгээг үзүүлэн, 91 кейст хамтарсан багийн үйлчилгээ үзүүлж шийдвэрлэсэн байна. Хавсралт : 5 зураг	100%
----	--	---	---	------

11	19.1.7.. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	"Монгол өрх" сэтгэл зүйн хүрээлэнтэй хамтран кейсийн хариу үйлчилгээг үзүүлж байна. Одоогоор 3 кейсд урт хугацааны нөхөн сэргээх сэтгэл зүйн зөвлөгөө хариу үйлчилгээг үзүүлж байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж баривчлагдсан иргэдэд "Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалт"-ыг сэтгэл зүйч Б.Баасанбат багштай хамтран зохион байгуулж 15 иргэн хамрагдсан. Түр хамгаалах байрны сэтгэл зүйчид 5 иргэнийг холбон зуучлах үйлчилгээ үзүүлсэн. Хамтарсан багийн нарийн бичиг, сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүдийн "Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд төрийн албан хаагчдын үүрэг, оролцоо, хариуцлага" үүрэг хүлээгчдийг чадавхжуулах сургалтыг "Үжин" төрийн бус байгууллагын тэргүүнтэй хамтран сургалт зохион байгуулсан. Тус сургалтад 22 хамтарсан багийн 150 гаруй гишүүдэд зохион байгуулсан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих хүрээнд шинээр байгуулагдсан түр хамгаалах байранд байгууллагын зүгээс шаардлагатай тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн. Хавсралт : 2 зураг	100%
----	--	--	------

12		19.1.8.. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж буй хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах зорилгоор Аймгийн Засаг даргын 2021 оны А/271 тоот захирамжаар “Шилдэг хамтарсан баг” -2 , “Хүүхдэд ээлтэй эцэг эхийн зөвлөл”-3 шалгаруулах журмын дагуу шалгарууллаа. Гэр бүл дэх хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах, Гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх, Гэр бүл, хүүхэд, залуучуудтай холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд болон иргэдийг сонсох, гэр бүлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулсан Гэрээр айлчлах аянаар аймгийн хэмжээнд 2816 өрхөд хүрч ажилласан. Гэр бүлийн боловсрол олгох ажлын хүрээнд: 16218 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. “Эцэг эхийн зөвлөл”-өөр дамжуулан 102 зөвлөл, 326 албан хаагчид зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан. “ХҮҮХДИЙГ ЗОДОЖ ШИЙТГЭХИЙГ ТАСЛАН ЗОГСООХ ДЭЛХИЙН ӨДӨР”- ийг тохиолдуулан “Эерэг хүмүүжил - Эерэг нийгэм” нэвтрүүлэг бэлтгэж, байгууллагын цахим хаяг болон орон нутгийн телевизээр олон нийтэд хүргэсэн. Олон Улсын Гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Гэр бүлийн үнэ цэнэ” нөлөөллийн арга хэмжээг Баруун - Урт сумын ЗДТГ-тай хамтран 9 багийн төлөөлөл 9 гэр бүлийн 18 иргэнийг хамруулсан уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцогчдоос уриалга гаргаж, уриалгыг олон нийтэд түгээсэн. Гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр 9 модуль хичээлийг байгууллагын цахим хаяг болон орон нутгийн телевиз олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэсэн. Гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр нийт 13 удаагийн постер, зөвлөмж зөвлөгөө, мэдээллийг олон нийтэд хүргэсэн Цагдаагийн газарт гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж түр саатуулагдаж байгаа иргэдэд "Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалт"-д 103 иргэнийг хамрууллаа. Аймгийн Засаг даргын захирамжаар Наран сумын Хүүхдэд ээлтэй сумаар шалгаруулж 2,0 сая төгрөгийн урамшуулал олгосон. Хавсралт : 4 зураг	100%
----	--	--	--	------

13		25.2.. Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно.	Аймгийн Цагдаагийн газарт 2004 оноос эхлэн гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргийн асуудлыг 1 байцаагч хавсран гүйцэтгэж байсан ба Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ батлагдсанаас хойш Гэр бүлийн хүчирхийллийн асуудал хариуцсан орон тооны байцаагчийг дангаар нь ажиллуулж эхэлсэн. Цагдаагийн газарт гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтний 1 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.	100%
14	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Аймгийн Хүний нөөцийн нэгдсэн суурь судалгааг Мерит төслийн 90,0 сая төгрөгийн санхүүжилттэй Майнд Плас судалгааны байгууллагатай хамтран нийт 132 байгууллагын 3593 албан хаагчийг хамруулан хийсэн. энэхүү хүний нөөцийн суурь судалгаанд үндэслэн аймгийн “Хүний нөөцийн нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”-ийг аймгуудад анх удаа жендерийн мэдрэмжтэй боловсруулан, 5 удаагийн хэлэлцүүлэг хийж, 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар 450 сая төгрөгийн төсөвтэй батлуулсан. Төрийн байгууллага бүр энэхүү хөтөлбөрийг үндэслэн нийгмийн баталгаа хангах хөтөлбөр батлуулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөр нь жендерийн мэдрэмжтэй, хувийн хэвшлийн байгууллагын санаачилга оролцоо хамтын ажиллагааг дэмжсэн, тодорхой төсөвт өртөгтэй гэдгээрээ онцлог болсон.	100%
15	Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29	16.4.. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн аймаг, нийслэл дэх дайчилж болох барилга байгууламжийн жагсаалтыг гаргаж Улсын онцгой комисст хүргүүлнэ.	Хуулийн дагуу аймгийн 13 сумдын хэмжээнд 29 байрлалд 670 иргэн хүлээн авах боломжтойгоор төлөвлөж нийт байрны 85 хувийг бүрэн ашиглан судалгааг гаргаж хүргүүлсэн.	100%

16	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ 2020-05-07 Дугаар 2020.07.01	15.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, хотыг хөгжлүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг өмнөх баримт бичиг дуусгавар болохоос өмнө батална. /Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./	Аймгийн таван жилийн үндсэн чиглэлийн төслийг бүх салбар, сумдаас санал авч боловсрууллаа. Шинээр батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Монгол улсын таван жилийн Үндсэн чиглэлд нийцүүлэн, салбар бүртэй хамтран хэлэлцэн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийг хуулийн шаардлагад нийцүүлэн томьёолж боловсрууллаа. Зорилго, зорилт, хүрэх үр дүн бүрд тохирсон 1 болон түүнээс доош тооны шалгуур үзүүлэлтүүдийг загвар хүснэгтийн дагуу боловсруулж улсын үндсэн чиглэлтэй уялдсан хүрэх үр дүнгүүдийг тодорхойлж гаргасан. Үндсэн чиглэлийн төсөл нийт 8 зорилго, 37 зорилтод чиглэсэн 136 хүрэх үр дүн, тэдгээрийг хэмжих 302 шалгуур үзүүлэлтүүдийг агуулсан	100%
17		17.4.. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг Засаг даргыг томилогдсоны дараах 45 хоногт багтаан батална.	Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, агентлаг албад, сумдаас санал авч аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хуулийн хугацаанд нь боловсруулсан. Боловсруулахад хуулийн шаардлагыг хангахын тулд Мерит төслийн дэмжлэгээр Удирдлагын академийн багшийн зөвлөмжийг уг баримт бичгийн төсөл дээр авч сайжруулан боловсруулж ҮХГ төслийг хүргүүлэн санал дүгнэлт авч түүнийг нэмж тусган АИТХ-р батлуулсан.	100%
18		18.6.. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор батална.	МУ-ын 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймгийг хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан Агентлаг албад хэлтэс, сумдаас санал авч аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж ЭЗХЯ-д хүргүүлсэн. Уг баримт бичгийг боловсруулахдаа 2023 оны улсын болон орон нутгийн төсвийн төсөлтэй төсвийн эх үүсвэрийг уялдуулан нийт 106 төсөл, арга хэмжээг төлөвлөж эдгээрийн шалгуур үзүүлэлт хүрэх түвшинг тодорхойллоо.	100%

19		21.6.. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтуудын орон нутагт дахь хэрэгжилтийн явц, үр нөлөөний тайланг аймаг, нийслэлийн Засаг даргаас Засгийн газарт тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтуудын орон нутагт дахь хэрэгжилтийн явц, үр нөлөөний тайлан, мэдээ тогтоосон хугацаанд, шалгуурын дагуу хүргүүлж байна.	100%
20	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, албад нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолуудыг мөрдлөг болгон хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаж байна. Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2019 оны 10/07 дугаар тогтоолоор батлагдсан “Сүхбаатар аймгийн хөгжлийн хэтийн зорилт”-д тус аймгийн хөгжлийн эрхэм зорилгыг “Мэдлэгт суурилсан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, тээвэр логистикийн хөгжлийн тулгуур төв болох” гэж тодорхойлсон ба тус аймаг нь тэргүүлэх чиглэлээ: - Нийгмийн тогтвортой хөгжил - Эдийн засгийн тогтвортой хөгжил - Байгаль орчны тогтвортой хөгжил - Засаглалын тогтвортой хөгжил гэсэн 4 чиглэлтэй байхаар тогтоож, дээрх тэргүүлэх чиглэлүүдийн дагуу 10 зорилго, 37 зорилтыг дэвшүүлсэн байна. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь орон нутгийн түвшинд батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээтэй уялдуулан эрхэм зорилгоо “Иргэн төвтэй, үр дүнд суурилсан төрийн албыг бэхжүүлж, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангана” гэж тодорхойлсон. Sukhbaatar.gov.mn сайт, “Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар” цахим хуудсыг тогтмол ажиллуулж аймгийн Засаг дарга, Тамгын газраас авч хэрэгжүүлж буй ажил, зорилт, арга хэмжээний талаарх мэдээллийг тухай бүр оруулж хэвшсэн.	100%
21		8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Аймгийн ЗДТГ-ын Sukhbaatar.gov.mn цахим хуудас, Төрийн байгууллагын удирдлага мэдээллийн ERP систем болон хэлтсүүдийн мэдээллийн самбар дээр 7 хэлтэс, нэгжийн бүтэц, чиг үүрэг, хаяг, албан хаагчдын харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаягийг тус тус байршуулсан	100%

22	8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	Байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд гаргасан ба холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж, Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газраас зөрчилгүй санал дүгнэлт авсан.	100%
23	8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн талаар нийт агентлаг албадын удирдлагад удирдах ажилтны сонсгол мэдээллийн цагаар аймгийн ЗДТГ-аас хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, нийтийн мэдээллийн ангилал, хариуцагч байгууллагуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч ажилласан. 2022 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлын хэсэг сумд, агентлаг төсөв байгууллагууд дээр ажиллахдаа хуулийн хэрэгжилтэд газар дээр шалгаж үнэлгээ өгсөн. Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ын мэдээллийн технологи харицсан бодлогын мэргэжилтэн тус хууль тогтоомжийг сурталчилан таниулах, үйл ажиллагаандаа хэрхэн уялдуулан хэрэгжилтийг хангаж ажиллах талаар сумд, байгууллагуудын холбогдох мэргэжилтүүдэд чиглэл өгч хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар арга хэмжээ авч ажиллаж байна. файл хавсаргах	100%

24	8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	АЗТГ нь чиг үүргээ хэрэгжүүлэх зорилго, зорилтын хүрээнд Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Хөгжлийн бодлогын баримт бичиг, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, Аймгийн 5 жилийн үндсэн чиглэл, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, захиргааны байгууллагын төлөвлөлтийн баримт бичигт гүйцэтгэлийн төлөвлөгөө, нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт бүрэн хэрэгжсэн, шилэн данс, Төрийн алба хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц үр дүнгийн талаарх тайлан, мэдээг тухай бүр албан ёсны хаяг Sukhbaatar.gov.mn, Shilen dans, АЗДТГ-ын газрын facebook цахим хаяг болон мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан үйл ажиллагааг ил тод нээлттэй байдлаар мэдээлж, ЗГХЭГ-ын цахим системд биелэлтийг тайгнаж байна.	100%
25	8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Аймгийн ЗДТГ-ын бүрэн эрх, чиг үүрэгтэй холбоотой 146 хууль, 60 журам мөрдөгдөж байна. Эдгээр хууль тогтоомжийг эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем https://legalinfo.mn/mn - ээс татан авч ашиглаж байна. Түүнчлэн аймгийн “Sukhbaatar.gov.mn” цахим хуудсанд өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгддэг 13 төрлийн хуулийг байршуулсан.	100%
26	8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Аймгийн Засаг даргын Тамгын газрын өргөдөл гомдол хариуцсан ажилтны нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, албаны цахим шуудангийн хаяг болон цагийн хуваарийг “Sukhbaatar.gov.mn”-д болон мэдээллийн самбарт ил тод байршуулсан.	100%

27	8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2007 оны 08 тоот албан даалгаврын дагуу аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас 2022 оны 4-р улирлын байдлаар ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайланг нэгтгэн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Тайлант хугацаанд аймгийн нийт төрийн захиргааны байгууллагад 17401 өргөдөл гомдол, санал хүсэлт, талархал ирсний 17165 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлт 98,2 хувийн үзүүлэлттэй байна. Хугацаа болоогүй 236 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд судлагдаж байна. Аймгийн хэмжээний нийт төрийн захиргааны байгууллагад иргэдээс хандаж гаргасан өргөдлийг агуулгаар нь ангилахад Нийгмийн даатгал, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст хандаж гарсан өргөдөл, хүсэлт зонхилж байна. 2022 оны 4-р улирлын байдлаар аймгийн Засаг даргад хандаж 100 өргөдөл, гомдол ирсэн байна. Эдгээрээс мөнгөн тусламж үзүүлэх зайлшгүй шаардлагатай иргэдэд эмчилгээний зардалд дэмжлэг үзүүллээ. Тайлант хугацаанд Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжин ирсэн 29 өргөдөл, гомдол, 4 талархлыг хугацаанд нь шийдвэрлэж хариуг өгсөн. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг байгууллагын мэдээллийн самбар болон Веб сайтад улирал бүр байршуулан иргэдэд мэдээлж байна Хавсралт : 1 файл	100%
28	8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	ҮСХ-ын даргын 2021 оны А/238 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад заагдсан мэдээ, тайланг график дагуу 2022 онд 13 сум, 67 баг болоод ҮСХ-ноос ирүүлсэн хүрээний дагуу ААНБ, өрх, иргэдээс албан ёсны статистикийн 40 нэр төрлийн 4405 мэдээллийг ҮСХ-ноос баталсан, зөвшөөрсөн маягт, аргачлалын дагуу цуглуулж, тогтоосон хугацаанд нь бүрэн дамжуулсан.	100%

29	8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	АЗДТГ-аас зохион байгуулж буй олон нийтийн шинж чанартай арга хэмжээний хөтөлбөр, удирдамжийг тухай бүр Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж байна.	100%
30	8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	2022 онд давхардсан тоогоор 221 ажлын байр зарласан бөгөөд 80 ажлын байр нөхөгдсөн байна. Хамгийн сүүлд 12 сард зохион байгуулсан тусгай шалгалтаар 63 ажлын байрны тусгай шалгалтыг зохион байгуулахад 24 ажлын байранд албан тушаалтан томилогдсон байна. Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд удирдах албан тушаалд 10 түр орлон гүйцэтгэгч, гүйцэтгэх албан тушаалд 34 түр орлон гүйцэтгэгч томилогдон ажиллаж байна.	100%
31	8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Аймгийн хэмжээнд төрийн захиргааны албан хаагчийг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам, загвар батлах тухай” 14 дүгээр тогтоол, “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам, загвар батлах тухай” 15 дугаар тогтоол, “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам батлах тухай” 16 дугаар тогтоолын дагуу зохион байгуулж байна. 2022 оны ерөнхий шалгалтыг 2 удаа зохион байгуулж нийт 286 иргэн бүртгүүлснээс 77 иргэн тэнцэж, нөөцөд бүртгэгдсэн байна. Тусгай шалгалтыг 3 удаа зохион байгуулсан бөгөөд 80 ажлын байранд албан тушаалтан томилогдсон байна.	100%

32		8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	2022 онд аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 1 сард болсон аймгийн удирдах ажилтны зөвлөгөөнд төрийн байгууллагын 120 удирдах албан тушаалтан, аймгийн соёлын байгууллагын албан хаагч, төрийн байгууллагын хүний нөөцийн мэргэжилтэн нар, сумдын бүх төрийн албан хаагч нарт “Төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг чадавхжуулах нь” сэдэвт сургалт зохион байгуулж арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн аймгийн Засаг даргын захирамжаар баталсан “Зөв хандлага-ээрэг нөлөө” аян зохион байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг эелдэг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх чиглэлээр байгууллага бүр идэвх санаачилга гарган ажиллахыг уриалсан. Аяны хүрээнд аймгийн төрийн байгууллагууд байгууллагын ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулах, төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн талаар байгууллага дотроо судалгаа авах, судалгааны үр дүнд шинэлэг бүтээлч ажил зохион байгуулах, байгууллагын албан хаагчийн ажлын байрны чиг үүргийн талаар олон нийтэд зориулсан, соён гэгээрүүлэх контент, бүтээл, мэдээ мэдээллийг түгээх, угтах үйлчилгээний соёл болон иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх тал дээр идэвхтэй ажилласан үр дүнтэй ажил боллоо. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга болон Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргын хамтран баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг бүх, сумд төрийн захиргааны байгууллагын албан хаагч нарт төрийн албан хаагчийн ёс зүй сэдэвт сургалтыг зохион байгуулж 780 орчим төрийн албан хаагчийн хамруулсан. Энэ хүрээнд төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	100%
----	--	--	---	------

33	8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Аймгийн “Хүний нөөцийн нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”-ийг 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар 450 сая төгрөгийн төсөвтэй батлуулсан. Хүний нөөцийн нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон хэрэгжилтийг хянаж үнэлэх журам боловсруулан батлуулахаар бэлтгэж байна. Байгууллага бүр нийгмийн баталгаа хангах хөтөлбөртэй бөгөөд энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний хэлтэс жил бүр хяналт тавин, үнэлгээ дүгнэлт зөвлөмж өгч, дүнг ил тод мэдээлдэг.	100%
34	8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Төрийн албан хаагчийн ажиллах орчин нөхцөл, сургалт хөгжил, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг аймгийн веб сайтад оруулж нийтэд ил тод мэдээлэн, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг байршуулж хэвшсэн. Аймгийн хүний нөөцийн нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам гаргаж ил тод нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулагдана. Сул орон тооны захиалга, төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтын зарууд төрийн албаны зөвлөлийн сайт болон аймгийн сайтаар ил тод мэдээлж хэвшсэн байна.	100%
35	8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу үнэлгээ өгч, дүгнэлт зөвлөмж гаргасан. 2022 оноос unelgee.gov.mn цахим систем аймгийн хэмжээнд нэвтэрсэнтэй холбоотой, үнэлгээ ил тод цахим хэлбэрээр явагдаж, гомдол санал гараагүй байна.	100%

36	8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 03 дугаар тогтоол болон 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн “Аймгийн 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 07 дугаар тогтоол, батлагдсан төсвийн холбогдох мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд мэдээлсэн. Аймгийн төсвийн 2022 оны төсвийн зарлага санхүүжилт, төсвийн орлогын гүйцэтгэлийн мэдээллийг өссөн дүнгээр сар бүр мэдээллийн самбарт шинэчлэн байршуулж байна.	100%
37	8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Төсвийн гүйцэтгэлийг Шилэн дансны тухай хуульд зааснаар хагас, бүтэн жилээр цахим хуудсанд байршуулсан болно. 2022 оны төсвийг аймгийн ИТХурлаар 2021 оны 12 сарын 02 ны 03 тоот тогтоолоор баталсан ба нийт орлого, зарлагыг 36.4 тэрбум төгрөгөөр баталсан. Төсвийн жилийн эцэст нийт татварын орлого 3.1 тэрбум төгрөгөөр давсан ба нийт зарлага санхүүжилтийг 100 санхүүжүүлж ажилласан. үүнээс сумдад 3.4 тэрбум төгрөгний санхүүгийн дэмжлэг, 4.2 тэрбум төгрөгийн ОНХСангийн хуваарилалт, орон нутгийн ашиглалтын тогтмол зардалд 4.5 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлж, гүйцэтгэлийг тооцсон байна. Мөн 2021 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цагалбарын дагуу төрийн аудитын байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулсан. 2022 оны хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлсэн. Сангийн тайлан, төсвийн сар бүрийн гүйцэтгэлийн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан болно.	100%

38	8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуульд заасан цагалбарын дагуу төрийн аудитын байгууллагад хүргүүлж дүгнэлт гаргуулсан. Дүгнэлтэнд аймгийн хэмжээний 105 төсөвт байгууллага, 32 төсөл сан, 18 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын тайлан нэгтгэдэг бөгөөд уг байгууллагуудын зөрчлүүд нийлж нийт 2.3 тэрбум төгрөг хүрсэнээр аймгийн санхүүгийн нэгтгэсэн тайлан хязгаарлалтай санал дүгнэлтыг авсан. Тайлан, дүгнэлтийг Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан болно.	100%
39	8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт ороогүй болно.	100%
40	8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	2022 оны төсвийн жилд Төсвийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор төсвийн байгууллагын төлбөр тооцоонд өдөр тутмын хяналт тавьж үр ашиггүй зардал гаргахгүй байх талаарх мэдээ мэдээллийг холбогдох албан тушаалтанд мэдээллэх, сумдын байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарт хуулийн заалтыг хэрэгжүүлэх талаарх сургалтыг өгч ажилласан. Мөн аймгийн төрийн сангийн хувьд батлагдсан төсвийн хүрээнд нийт 30.7 тэрбум төгрөгний зарлага санхүүжилтийг хийж гүйцэтгэсэн ба төрийн сангийн төлбөр тооцооны систем нь төсвийн хэтрэлт гаргах боломжгүй байдаг тул хэтрэлт гараагүй болно.	100%
41	8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	Шилэн дансны цахим хуудсанд сар бүрийн 8-ны дотор таван сая, түүнээс дээш төгрөгний үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг тогтмол оруулсан.	100%
42	8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгний гүйлгээг Шилэн дансны тухай хуульд заасан цагалбарын дагуу шилэн дансны цахим хуудсанд сар бүр тогтмол байршуулсан. Хавсралт : 1 файл	100%

43	8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	Шилэн дансны тухай хуульд заасны дагаа цахим хуудсанд байршуулсан болно. Хавсралт : 1 файл	100%
44	8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	Шилэн дансны хөтлөлтийг бүрэн хэвшсэн ба 2022 оны 7 сараас эхлэн шинээр нэвтрүүлж буй цахим системд аймгийн бүх төсөвт байгууллага, өмчит үйлдвэрийн газар, ерөнхийлөн захирагч нар бүртгүүлсэн. 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд: төсвийн байгууллагын НББ-ын программыг сайжруулахаар CTS программыг нийт 58 байгууллагад шинэчилсэн, өр,авлагыг бууруулах талаарх хууль хяналтын байгууллагад хандах, нягтлан бодогч нарын мэдлэг мэдээлэл, ур чадварыг нэмэгдүүлэхээр 4 удаагийн сургалт, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх зэргээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	100%

45	8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй үндэслэлийг tender.gov.mn сайтад байршуулсан. Сүхбаатар аймгийн 2022 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөг 2021 онд аймгийн Засаг даргын А/721 дүгээр захирамжаар 59 нэр, төрлийн бараа, ажил, үйлчилгээ 8836,4 сая төгрөгийн төсөвтэй батлагдсан. Төлөвлөгөөг батлагдсан даруй Зууны мэдээ сонины 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 254/6731/ дугаартай сонин, мөн төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn сайтад оруулсан. Уг төлөвлөгөөнд 2022 оны аймгийн Засаг даргын А/74 дүгээр захирамжаар, 2022 оны 05-р сарын 20-нд аймгийн Засаг даргын А/272 дугаар захирамжаар, 2022 оны 10-р сарын 13-ны Засаг даргын А/524 дүгээр захирамжуудаар тус тус өөрчлөлт орж шинэчлэн байгуулсан. 2022 оны аймгийн Засаг даргын А/524 дүгээр захирамжаар батлагдсан төлөвлөгөөнд: Орон нутгийн төсвийн хөрөнгөөр: 58 нэр, төрлийн 10430,2 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний тендер, Улсын төсвийн хөрөнгөөр: 14 нэр, төрлийн 33426,5 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний тендер, “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн санхүүжилтээр 2 нэр төрлийн 201,3 сая төгрөг, харьяа байгууллагын мэргэжлийн байгууллагаар тендер зарлуулах тухай хүсэлтийг үндэслэн 3 нэр төрлийн 173,9 сая төгрөг, Нийт 77 нэр, төрлийн 44231.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний тендерийг зарлахаар төлөвлөснөөс өнөөдрийн байдлаар 72 нэр төрлийн 43629,5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний тендерийг зарласан. Үүнээс 64 гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 33948,4 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 94,6%-тай байна.	100%
46	8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан улс, орон нутгийн төсөв, замын сан, удидлагыг хэрэгжүүлэх зардал бусад чиг үүргийн сангийн хэрэгжилтэд аудит хийсэн. Аудитын хяналтаар зөрчилгүй дүгнэлт авсан ба тайланг байгууллагын самбар, shilendans.gov.mn сайтад байршуулсан болно. Хавсралт : 1 файл	100%

47	8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтыг 2022 оны 03 сарын 25-27-ны өдрүүдэд 127 хүн, 2022 оны 04 сарын 22-25-ны өдрүүдэд 45 хүн, нийт 172 хүн хамрагдсан Сургалтын үр дүнд нийт 110 хүн Худалдан авах ажиллагааны АЗ сертификат авсан байна. Мөн Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн нь 2022 оны 06 дугаар сарын 02-15-ны өдрүүдэд 12 суманд томилолтоор ажилласан бөгөөд 2020, 2021, 2022 оны худалдан авах ажиллагааны үйл явцтай танилцах, зөвлөн туслах, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зааврыг нийт 60 албан хаагчдад өгсөн байна. Энэ онд үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд нийт давхацсан тоогоор 312 иргэн орж ажилласан. Мөн Нийт 544 хүн хамрагдсан. Харьяа 10 байгууллагын үнэлгээний хороонд албан хаагчид орж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Үүнд Аймгийн нэгдсэн эмнэлэгт 2, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албад 1, Онцгой байдлын газарт 2, Цагдаагийн газарт 1, Байгаль орчин аялал жуулчлалын газарт 4 төсөл арга хэмжээ байна. Мөн худалдан авах ажиллагааны цахим систем болон хуулийн талаар 11 байгууллагад арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	100%
48	8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	Тус албанд төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт байхгүй болно.	100%
49	8.4.27. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	Аймгийн Хүний нөөцийн нэгдсэн суурь судалгааг Мерит төслийн 90,0 сая төгрөгийн санхүүжилттэй Майнд Плас судалгааны байгууллагатай хамтран нийт 132 байгууллагын 3593 албан хаагчийг хамруулан хийсэн. энэхүү хүний нөөцийн суурь судалгаанд үндэслэн аймгийн “Хүний нөөцийн нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”-ийг аймгуудад анх удаа жендерийн мэдрэмжтэй боловсруулан, 5 удаагийн хэлэлцүүлэг хийж, 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар 450 сая төгрөгийн төсөвтэй батлуулсан.	100%

50	8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)	Төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг shilen dans.gov.mn, sukhbaatar.gov.mn сайтууд болон байгууллагын мэдээллийн самбар, Сүхбаатар аймгийн Орон нутгийн өмчийн газар" пэйж хуудсанд тогтмол байршуулж хэвшсэн.	100%
51	8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	Төрийн цахим шилжилтийн хүрээнд МУ-ын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.17. Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг үе шаттай нэвтрүүлж, цахим хэлбэрт шилжүүлэх замаар төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, цаасгүй, хүнд сурталгүй хүргэж цахим засгийг бодитой хэрэгжүүлнэ гэж заасны дагуу Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд e-mongolia.mn системд 13 байгууллагын 74 үйлчилгээний жагсаалтыг байгууллагын sukhbaatar.gov.mn веб хуудсанд холбож ажиллалаа. Тухайн үйлчилгээнүүдийн холбогдох баримт бичиг, дансны мэдээлэл, үйлчилгээний төлбөрийн мэдээллийг бүрэн байршуулж ажилласан. Хавсралт : 1 зураг	100%

52		8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	Аймгийн Засаг даргын 2022 оны А/157 дугаар захирамжаар боловсролын байгууллагуудын сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай сунгасан. 2022 онд боловсролын 9 ерөнхий боловсролын сургууль, 22 цэцэрлэгийн хүсэлтийг Е-Монголиа цахим системээр хүлээн авч хугацаанд нь хариу өгч ажилласан. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлыг нийт 7 удаа зохион байгуулж 5 байгууллагад шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар олгож, 16 байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгаж хуулийн дагуу аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулсан байна.Хугацаа сунгагдсан эрүүл мэндийн байгууллагын 92.3% нь эмийн сан байна. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах ЭХ/10/15/17 тусгай зөвшөөрлийн гэрчилгээтэй Баруун-Урт Эхэн ус эмнэлгийн арьс харшлын эмнэлгийн үйл ажиллагааг хүчингүй болгосон. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт орж Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 480 дугаар тушаалын дагуу тусгай зөвшөөрөл олгох комиссын даргыг аймгийн Засаг даргын захирамжаар томилон шинэчилсэн журмаар ажиллахаар бэлтгэл ажлыг хангаад байна. Хавсралт : 1 файл	100%
----	--	--	--	------

53	8.6.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	1. албан байгууллагуудаас шинээр батлагдсан хууль тогтоомж, хуулийн төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулахаар албан бичгээр хандсаны дагуу тухай бүр хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлж ирсэн. Тухайлбал сургалт, хэлэлцүүлгийн байраар хангах, орон нутгийн BBS телевизэд зар мэдээллийг үнэ төлбөргүй явуулах, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх, цайны завсарлагыг зохион байгуулах, мэдээлэл бэлтгэж аймгийн албан ёсны веб сайтад байршуулах зэргээр ажиллаж байна 2. “Найрсаг Баруун-Урт”, “Хуульчийн Про Боно өдөр” зэрэг бүх албан байгууллага, аж ахуй нэгжүүдийг хамарсан томоохон хэмжээний өдөрлөг, Багийн засаг дарга нарын уулзалт, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулга уулзалт зэрэг арга хэмжээнд оролцож, иргэд олон нийтэд шинээр батлагдсан хууль тогтоомж, хууль тогтоомжид орсон онцлох өөрчлөлт, зохицуулалт, эрх зүйн мэдээ мэдээллийг хүргэх, гарын авлага, материал тараах, хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх зэрэг ажлуудыг зохион байгуулж ажилладаг. Тухайлбал, Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Хууль зүйн туслалцааны тухай хууль /Шинэчилсэн найруулга, Тоон гарын үсгийн тухай хууль, Засгийн газар дахь хяналтын тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон 2023 оны 01 дүгээр сарын 01-ээс дагаж мөрдөгдөх онцлох хуулиудаар 1200 төрийн албан хаагчид болон иргэдэд нийт танхимын болон цахим хэлбэрээр мэдээлэл өгч ажилласан. Мөн эрх зүйн сурталчилгааг үр дүнтэй, хүртээмжтэй хэлбэрээр хүргэх зорилгоор "Иргэн таны хууль, эрх зүйн мэдлэгт- Сүхбаатар аймаг Хууль, эрх зүйн хэлтэс" нэртэй фейсбүүк хуудас ажиллуулж, уг хуудсаар дамжуулан ажлын өдөр бүр иргэд олон нийтэд чиглэсэн хууль тогтоомж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон тус хэлтсээс зохион байгуулсан арга хэмжээний мэдээллийг хүргэж ажиллахаар зорьж байгаа бөгөөд 53 мэдээ, мэдээллийг нийтэлж, олон нийтэд хүргэлээ.	100%
54	8.6.2. эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	МУГБ Ш.Чулуунборын Шинжлэх ухаан утга зохиолын бичмэл 2 бүтээлийг Оюуны өмчийн газрын даргын 2016.07.05-ний А/75 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгүүлсэн . Үүнд: 1. Монгол бичиг заах аргын зарим асуудал, 2. Монгол бичгийн зарим хүнд сэдвийн заах арга шалгалтын материал. Сүхбаатар аймгийн Халзан сумын 3-р багийн иргэн М.Батжаргал "Тааны сорс"-оор оюуны өмчийн эрх авсан.	100%

55	8.6.3. хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	Аймгийн засаг даргын захирамжаар байгуулагдсан Баруун-Урт сумын амгалан гэр хорооллын дахин төлөвлөлт, тандалт судалгаа, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө ажлын даалгавар боловсруулах, мэргэжил аргазүй, шаардлагатай мэдээллээр хангах ажлын хэсэг байгуулагдаж энэ ажлын хүрээнд 3 удаа хуралдан тооцоо судалгаа, хэсэгчилсэн төлөвлөгөөнд орох газрын байршил, тооцоо судалгааг гарган ажлын даалгаварт тусгаж, ажил гүйцэтгэгчийг шалгаруулж 80 сая төгрөгөөр гүйцэтгэгч “Ланд овнер” ХХК шалгараад тандалт судалгаа, хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах ажил явагдаж байна. Гүйцэтгч компанид шаардлагатай судалгаа, мэдээллээр тогтмол хангаж, хээрийн судалгааны ажилд хамтран ажиллаж байна. Аймгийн ажлын хэсэг болон аймгийн ИТХ-аар 12 дугаар сард хэлэлцүүлж хэсэгчилсэн төлөвлөгөөг батлуулахаар ажиллаж байна.	100%
56	8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Засаг даргын 2012.04.25 ны өдрийн 39 дүгээр захирамжаар 160400089 дугаар бүхий 2152 м/кв буюу 0,21 га газрыг 15 жилийн хугацаатай Төрийн үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлсэн.	100%
57	8.6.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	Тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын талаарх тайлан мэдээг холбогдох хуулийн дагуу хугацаанд нь тайлагнан гаргадаг.	100%

58	8.6.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;	төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээллийг харьяа орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад мэдээлэл өгч санхүүгийн тайлан гаргасан хугацаанд мэдээллийг үүрэг болгон ажиллана.	70%
59	8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөд 5.7 тэрбум төгрөгний хөрөнгийг эрх бүхийн байгууллагын шийдвэрээр балансаас балансад шилжүүлсэн, акталсан, данс хооронд шилжүүлсэн, бусад зэргээр хасагдсан байна. Мөн аймгийн ИТХурлын 77 тоот тогтоолоор Дөрвөлж ОНӨААТҮГ-азар, аймгийн ЗДТГ-ын 5 ширхэг хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар борлуулахаар шийдвэрлэж 3 удаагийн дуудлага худалдаа зохион байгуулж 55.7 сая төгрөгний хөрөнгө борлуулж төрийн сангийн дансанд тушаасан болно.	100%

60	8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудыг идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмрээ оруулахыг уриалж сумдын засаг даргын тамгын газарт албан тоот хүргүүлснээр 13 суманд мод тарих тарих 302 иргэнийг мод тарих ажилд хамруулж 49970 мод тарьж байгаль орчинд ээлтэй ажилласан. 2.Томуу томуу төст өвчин эхэлж байгаатай холбоотойгоор “Бяцхан үрс өвдөггүй” аяныг эхлүүлж 0-5 насны зорилтод бүлгийн 310 хүүхэд болон байгууллагын ажилтан, албан хаагчдын хүүхдүүдийг витаминжуулах, дулаан хувцас, халдвар хамгаалал ариутгалын зүйлс олгох зэрэг ажлыг санаачлан хийсэн.3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөлөлд 2023 онд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний 16-н дүгнэлт боловсруулан гаргаж, www.ies.mn мэдээллийн талаарх санд оруулан ажилласан болно.	100%
61	8.6.11. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	Улс орон нутаг, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар аймагт хэрэгжсэн 19 барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийн дагуу Улсын комиссын бүрэлдэхүүн ажиллуулж байнгын ашиглалтад оруулан дүгнэлтийг баталгаажуулан ажилласан.	100%
62	8.6.13. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;	Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолын хүрээнд аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга, Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай хамтын ажиллагааны гурвалсан гэрээ байгуулж www.iltodgere.mn эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд 2022 онд байгуулсан хамтын ажиллагааны 14 гэрээнээс 8 аж ахуй нэгжийн гэрээг байршуулан баталгаажуулсан, 6 гэрээ оруулах бэлтгэл ханган ажиллаж байна.	100%

63		8.6.20. нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6.20. дахь нээлттэй мэдээллийн тайлагналтыг цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 2022 оны 10 сард хүргүүлсэн. Хавсралт : 1 файл	100%
64		8.6.21. мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцаж байгаа оюутан байхгүй.	100%
65		8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана.)	Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод нээлттэй байдлаар байгууллагын веб сайт болон олон нийтийн цахим сүлжээгээр мэдээлэн ажиллаж байна.	70%
66	Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2021-12-24 Дугаар 2021-12-24	11.3. Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Улсын Их Хуралд ирүүлэх ба түүнд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод хүргүүлнэ. (11.2.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана.)	МУ-ын хуулийн 8, заалт 68, УИХ-ын тогтоол 1, заалт 1, УИХ-ын байнгын хорооны тогтоол 4, заалт 5, Ерөнхийлөгчийн зарлиг 5, заалт 14, ЗГ-ын тогтоол 7, заалт 14, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл 7, заалт 10, ЗГ-ын албан даалгавар 2, заалт 2, ҮАБЗ-ийн зөвлөмж 4, 8 заалт хяналтад авсан нийт 38 шийдвэрийн 122 заалт арга хэмжээний хэрэгжилтийг МУЗГХЭГ-ын хяналт-шинжилгээ үнэлгээний мэдээллийн цахим санд нотлох баримтын хамт баталгаалж байна. Хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал гаргаагүй болно.	100%

67	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи́дан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-07-05 Дугаар 2023.01.01	15.7. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, эрүүл мэнд, соёл, спортын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон дотуур байрны байршил, аймаг, нийслэлийн саналыг харгалзан хүнс, эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тогтооно.	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи́дан согтуурахтай тэмцэх тухай хуулийг сурталчлах ажлыг онлайн групп байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдэд цаг хугацаанд хүргэж ажиллаж байна. 2022 онд аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн 195 аж ахуй нэгжийн 250 цэгт үйл ажиллагаа явуулж, хүн амын тоонд харьцуулан тогтоосон нормативаас хэтрээгүй болно. Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөл сунгах 105 , шинээр авах 20 , аж ахуйн нэгжийн хүсэлтийг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн. Үүнээс: Оюутан, сурагчдын хичээлийн болон дотуур байрны байршилд 5 ААН, эмнэлэг, эрүүл мэндийн байршилд 3 ААН, соёл, спортын хүрээнд 4 ААНэгж дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна. 12 сумын 75 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрөлийг шинээр олгох, сунгах үйл ажиллагааг засаг даргын захирамжаар хэрэгжүүлсэн.	100%
68		23.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно.	Аймгийн Засаг даргын 2016 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/80 дугаар захирамжийн дагуу цагийн хуваарийг тогтоон ажиллаж байна. Хавсралт : 1 зураг	100%
УИХ-ын тогтоол				

69	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2021-07-07 Дугаар 2021 №67	1.1.ж/. цар тахлын үед хүүхэд, зорилтот бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах, хүүхэд хамгааллын байцаагчийн тоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын асуудалд нэн шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг ямар ч нөхцөлд хасахгүйгээр, цогц байдлаар төсөвлөх, шаардлагатай тохиолдолд төсвийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:)	Хүүхдийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт нөхцөлд өртсөн хүүхдэд эрүүл мэндийн болон сэтгэлзүйн дэмжлэгийг хэрхэн үзүүлэх тухай, хүүхдийн аюулгүй байдлыг хэрхэн хангах гэх мэт 55 төрлийн зөвлөгөө, зөвлөмжийг “Хүүхдийн мэргэжилтэн зөвлөж байна” хуудсаар дамжуулан хүргэж байгаа бөгөөд 6985 хандалттай байна. Хамтарсан баг, Хүүхэд хамгааллын багийн гишүүд гэрийн эргэлт хийж эрсдэлтэй 179 тохиолдлыг илрүүлж хүнсний дэмжлэг болон хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж ажилласан байна. Дээрх үйл ажиллагаанд нийт 2,917,500 төгрөгийг зарцуулж ажилласан. Хавсралт : 4 зураг	100%
УИХ-ын байнгын хорооны тогтоол				
70	Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ	3.1/. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, (2018-2020 оны сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчний статистик ирүүлэх)	Эрсдэлт бүлгийн хүн амыг БЗДХ-ыг илрүүлэх идэвхтэй илрүүлгийн үзлэгт хамруулах ажлыг аймгийн засаг даргаас сумдын засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусган ажиллаж Мөнххаан, Баяндэлгэр, Түвшинширээ, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Асгат, Түмэнцогт сумдын 15-49 насны 12447 иргэд, зорилтот бүлгийн 5044 хүн амыг ХДХВ /ДОХ/ БЗДХ урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамруулснаас тэмбүү өвчний хуучин тохиолдол -280, шинэ тохиолдол -12-ыг илрүүлж хавьтлын эмчилгээг 100 хувь хийлгэсэн байна. Хавсралт : 1 файл	100%

71	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ	2.1/. Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах;	Эрсдэлт бүлгийн хүн амыг БЗДХ-ыг илрүүлэх идэвхтэй илрүүлгийн үзлэгт хамруулах ажлыг аймгийн засаг даргаас сумдын засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусган ажиллаж Орон нутгийн төсвөөс 48,5 сая төгрөгийг зарцуулан Мөнххаан, Баяндэлгэр, Түвшинширээ, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Асгат, Түмэнцогт сумдын 15-49 насны 12447 иргэд, зорилтот бүлгийн 5044 хүн амыг ХДХВ /ДОХ/ БЗДХ урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамруулснаас тэмбүү өвчний хуучин тохиолдол -280, шинэ тохиолдол -12-ыг илрүүлж хавьтлын эмчилгээг 100 хувь хийлгэсэн байна. Мөн Эрүүл Сүхбаатарчууд төлийг хэрэгжүүлэн Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэдийг үзлэг шинжилгээнд хамруулах оношлуурын зардалд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас 37,8 сая төгрөгийг шийдвэрлэн ажиллаа.	100%
72		2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/528 дугаар тушаалаар батлагдсан Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг баримтлан ажиллаж байна. Орон нутгийн төсвөөр Эрүүл Сүхбаатарчууд 3.1 тэрбум төгрөгийн өртөгтэй / 2 жилийн хугацаанд хэрэгжих хөтөлбөр / Явуулын амбулаторийн үзлэг 53.5 сая Олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр МСЭМХ, Глобал сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн хавьтлын илрүүлэг үзлэг 8. 7 сая /Глобал сан/ "СҮРЬЕЭГҮЙ ЭРДЭНЭЦАГААН" 1.4 сая /Глобал сан/ "Гепатитгүй Монголчууд " 500 сая /Олон улсын Ротари сангийн санхүүжилт/	100%

73	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ	3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах.	Сүхбаатар аймгийн хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдийн хэлэлцүүлгийг аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Баруун-Урт сумын хамтарсан баг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн мэргэжилтнүүд байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөлийн төлөөлөл, хүүхдийн оролцооны байгууллагын төлөөлөл, хүүхдийн элчийг хамруулан 81 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үр дүнд гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх, эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, цэцэрлэг болон сургуулийн бага ангийн хүүхэдтэй эцэг эхчүүд хүүхдээ цэцэрлэгт өгөх, авах цаг нь ажлын цагтай давхацдаг тул байгууллагын удирдлагуудад Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар байгууллагын дотоод журам, Хүүхэд хамгааллын бодлогодоо зохицуулалт хийж ажиллах тухай чиглэл өгсөн. Боловсролын байгууллагын дотуур байран дахь хүүхэд хамгааллын асуудлаар дотуур байрын багш нарын "Үндэсний сургалт" уулзалт хэлэлцүүлгийг 2022.10 сард зохион байгуулж, сургалтад ЕБС-ийн “Хүүхэд хамгааллын баг”-ийн ахлагч, гишүүд, МСҮТ-ийн дотуур байрын багш, нийгмийн ажилтан, эмч нар хамрагдаж нэгдсэн ойлголттой болсноор дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын асуудалд ахиц гарах боломж нэмэгдэж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хамгаалах байрын урсгал зардалд 90,0 сая төгрөгийг орон нутгаас шийдвэрлэн хэрэгжүүлж байна Хавсралт : 4 зураг	100%
----	---	---	---	------

74	Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ	1.6/. Улсын хэмжээнд сум бүрийг “Ахмадын өргөө”-тэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх, ажиллаж буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх;	Аймгийн хэмжээнд 12 сумын ахмадын хөгжлийн төв, аймгийн Ахмадын ордон үйл ажиллагаа идэвхтэй явуулж байна. 2022 оны орон нутгийн төсөвт сумдад 6000.0-17000.0 мян, төгрөгийн үйл ажиллагааны зардлыг тусгаж, цаг хугацаанд нь санхүүжүүлэн, холбогдох урсгал зардал, ажиллаж буй ахмад настны урамшууллыг тухай бүр олгов. Аймгийн Засаг даргын 2021 оны 154 дүгээр захирамжаар 2020-2024 онд ахмад настны чиглэлээр хэрэгжүүлэх 90 бүтээлч ажлын чиглэл, төлөвлөгөөг батлан, сум, холбогдох байгууллагуудад хүргүүлэн, холбогдох арга хэмжээг зохион байгуулж, байна. Ахмадын хөгжлийн төв, танхим, ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2023 оны орон нутгийн төсөвт 7000.0-30000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгохоор тусгалаа.	100%
Ерөнхийлөгчийн зарлиг				

75	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч 30 байгууллагаас 19 , 13 сумын төсөвт 78 байгууллагаас 53 байгууллага гадна хаягаа монгол бичгээр бичиж байрлуулсан. Нийт байгууллагын хаягжилтын хувь 65,5% 2022 онд шинээр 79 аж ахуйн нэгж монгол бичгэн гэрлэн хаягийг шинээр хийж хэрэгжүүлсэн. Байгууллагын доторх өрөө тасалгааны хаяг, танилцуулга самбар, ажилчдын энгэрийн тэмдэг, өргөмжлөл талархлыг монгол бичгээр хэвлэдэг 24 байгууллага байна. Баруун-Урт суманд 4 гудамжны нэрийг Үндэсний бичиг крилл, англи хэлээр хослуулан бичиж байрлуулсан. Аймгийн Засаг дарга хэрэгжүүлэгч агентлаг болох 14 байгууллагад 170,0 сая төгрөгийн гадна гэрэлтүүлэг , гэрлэн хаягийн дэмжлэг үзүүлсэн. Монгол хэл, бичгийг дээдлэгч сумаар Баяндэлгэр сум Засаг дарга түүний тамгын газар, Монгол хэл бичгийг дээдлэгч иргэнээр Түмэнцогт сумын иргэн, монгол хэл бичгийг дээдлэгч багшаар Баруун-Урт сумын 1-р сургуулийн багш нарыг шалгаруулж 2,8 сая , Элсэлтийн ерөнхий шалгалтад массын амжилт гаргаж монгол хэлний хичээлээр 20-оос дээш сурагч бэлтгэж 550-600 оноо авсан монгол хэлний 1 багшийг 1,0 сая, бусад 4 багшийг тус бүр 100,000 төгрөгөөр урамшуулсан. Аймгийн хэмжээнд нийт 7 иргэн 3,6 сая төгрөгийн урамшуулал олгосон . Үндэсний бичиг, эх хэлээ түгээн дэлгэрүүлэхэд идэвх санаачилгатай ажиллаж буй багш нараас БШУЯ-ны “Бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэгч”-3, “Алтан гадас” одонгоор-1, Монгол улсын гавьяат багш” -1 нийт 5 багшийг төрийн одон медальд тодорхойлж алдаршуулсан. Сүхбаатар аймгийн хэлний бодлогын зөвлөлийн гишүүн Баруун-Урт сумын 3-р сургуулийн монгол хэлний багш 2022 оны 09 дүгээр сард “Хэл шинжлэлийн ухааны доктор “ цолыг “Монгол хэлэнд туссан хийсвэр ертөнцийн дүр зураг” сэдвээр амжилттай хамгаалсан. Шинэ докторыг аймгийн Засаг дарга 1,4 сая төгрөгөөр урамшуулсан. Хавсралт : 4 зураг	100%
----	---	--	--	------

76	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104	1.16.. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих	ЭМ-ийн сайдын 2021 оны 06 сарын 15-ний өдрийн А/370 тоот тушаалын дагуу, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2 дэх заалтыг үндэслэн 'Хүүхдэд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний сурталчилгааг сургууль, цэцэрлэгийн орчинд хийх, байршуулахыг хориглосон зөвлөмж зөвлөгөөг 2022-2023 оны хичээлийн жилийн эхэнд 16 ЕБС, 24 цэцэрлэгийн орчинд байрлах худалдаа үйлчилгээний газруудад сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон 11 нэр төрөл бүхий хүнсний бүтээгдэхүүний жагсаалт-ыг брошур хэлбэрээр гарган зөвлөмж мэдээлэл хүргэсэн.	100%
77	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах	Тэр бум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд 2 удаа “Бүх нийтээр мод тарих аяныг зохион байгуулахад 297 ААНБ-ын 10260 иргэн оролцож 9 төрлийн 303402 ш мод тарьж 625,0 сая төгрөг, мөн БХНСАХЗ –аас нийт 223.9 сая төгрөг, улсын төсвөөр 103,0 сая, сумын хөгжлийн сангаас 388,5 төгрөг, тус тус зарцуулагдсан байна. Нийтийн эзэмшлийн талбайд мод тарих, арчлан хамгаалах ажилд ХХҮГ-аас аймгийн хэмжээнд 2002 иргэнийг түр ажлын байраар / ногоон ажлын байраар / хангаж 32000 ш мод тарьсан байна. Үүнд 77 сая төгрөгийг цалинд зарцуулсан байна Хавсралт : 5 зураг	100%

78		1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох	Аймаг, орон нутагт ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын хүрээнд Уртын голын дагуух тохижилт "Сүхбаатар соёл амралтын хүрээлэн" нэртэйгээр 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9 тэрбум төгрөгийн зам, барилгын ажил эхэлж энэ оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 3 тэрбум төгрөгийн ажлыг "Монгол зам" ХХК гүйцэтгээд байна. Сүхбаатар соёл амралтын хүрээлэнд нийтдээ 40 га талбайд эрэг болон зүүн авто замын хооронд 2,5 км урт тохижилт хийгдэнэ. Төлөвлөлт хийх 40 га талбайн 20,7га талбайд ногоон байгууламж, 4,1 га-д амрах талбай /задгай театр, мини парк, спорт талбай, тоглоомын талбай, ахмад настан бялдаржуулах, 0,6га-д явган зам, 1,7га-д 2,5 км урт 5 м өргөнтэй дугуйн болон гүйлтийн зам, 0,4га-д хиймэл нуур, 0,4га-д үйлчилгээний цэг, 1,0га-д 315 автомашины зогсоол болон дугуйн зогсоол байхаар төлөвлөн гүйцэтгэж байна. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсэг аймгийн Засаг даргын А/747 дугаар захирамжаар байгуулагдаж нэгдсэн хөтөлбөр төлөвлөгөө гаргаж "Ногоон Сүхбаатар" аяныг "Хогийг мөнгө болгоё, модыг төгөл болгоё" уриаг дэвшүүлэн ажилласан. Аймгийн зөвлөгөөнийг 2-р сард хийж 110 хүн оролцсон. Төлөвлөгөөний дагуу аймгийн хэмжээнд Зөвлөгөөн-1, Сургалт- 15, 17 төрлийн гарын авлага - 4100, ном -100 ш, мэдээллийн самбар- 11ш, Шторк-2 төрөл, 10 стекер хийсэн бөгөөд сурталчилгааг орон нутгийн BBS телевиз давхардсан тоогоор 10 удаа, МҮОНТ-ийн орон нутаг дахь салбар INFO 6 удаа, байгууллагын веб сайт пэйж FB хуудас 15 удаа мэдээллийг бэлтгэн олон нийтэд хүргэж нийт 76800 хүний хандалтыг авч сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Танхимын болон цахим сургалтад 225 хүн хамрагдсан байна. Хавсралт : 3 зураг	70%
----	--	--	---	-----

79		1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах	Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх ажлын хүрээнд 2021-2028 онд Сүхбаатар аймгийн 13 суманд хэрэгжиж байгаа “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төсөлд хөв цөөрөм байгуулах санал хүргүүлсний үр дүнд Газрын доорх усыг хуримтлуулах далд систем барьж байгуулах судалгаа тооцооны ажлыг 2023 онд хийхээр төлөвлөгдөөд байна. Мөн модны усалгааны асуудлыг оновчтой шийдвэрлэх ажлын хүрээнд Хөдөө аж ахуйг дэмжих санд санал тавьж орон нутгийн төсвийн хөрөнгөөр Баруун-Урт суманд 1 га-гийн 5 ш услалтын системийг 37.5 сая төгрөгөөр авч ашиглаж байна. Тус аймаг нь гол горхи, гадаргын усгүй бүс нутаг хөв цөөрөм байгуулах боломж нөхцөл бага байдаг.	70%
----	--	---	--	-----

80		1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх	“Мод тарьж ургуулах арга, дэвшилтэт технологи”-ийн талаар аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 12 хүн ХААИС-д 2022 оны 02 сар туршлага судалсан. ХААИС-тай хүний нөөц бэлдэх талаар 2022 оны 03 сард тус сургуулийн захирал, аймгийн Засаг дарга нар хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурсан. Энэхүү санамж бичгийн үр дүнд МСҮТ-д Ойжуулалтын анги нээгдэж байгаатай холбоотойгоор тус төвийн багшийг ХААИС-д “Ойн аж ахуйн инженер” мэргэжлээр 2.5 жилийн хугацаатай, орой эчнээ ангид бакалавр зэргээр сургаж, зардлыг аймгийн төсвөөс хариуцаж байна. Сургалтын үйл ажиллагаа 10 сард эхэлсэн. Уг ажлын үр дүнд ХААИС-ийн туршин хэрэгжүүлж буй мод тарьж ургуулах шинэ дэвшилтэт технологийг МСҮТ-ийн Ойжуулалтын ангиар дамжуулан орон нутагт нэвтрүүлэх боломж бүрдэж байна. Аймгийн хэмжээнд 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 108.4 га газрыг “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламж байгуулах, ойжуулалт, ойн зурвас байгуулах газрын байршлыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан. Эрдэнэцагаан сумын “Номинбогд” ХХК, Мөнххаан сумын “Хос далбаа” ХХК, , Сүхбаатар сумын “Дорнод шим агро” ХХК, Түмэнцогт сумын “Хэрлэн алтай” ХХК, “Газрын чимэг” ХХК, “Үргэлж бадрал” ХХК, “Түмэнцогт ургац” ХХК, иргэн Г.Энхбат, “Фермерагро”ХХК-ууд зэрэг 9 байршилд өөрийн эзэмшлийн газарт нийт 30,8 га талбайд 2030 он хүртэл 3 эгнээ ойн зурвас байгуулахаар гэрээ байгуулан ажиллаж байна.	70%
----	--	---	--	-----

81		2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Ногоон Сүхбаатар" аян зохион байгуулж "Хогийг мөнгө болгоё, модыг төгөл болгоё" нэгдсэн хөтөлбөр төлөвлөгөө гаргаж уриалга дэвшүүлэн ажилласан. Төлөвлөгөөний дагуу аймгийн хэмжээнд Зөвлөгөөн-1, Сургалт- 15, мэдээллийн самбар- 11ш, Шторк-2 төрөл, 10 стикер хийсэн бөгөөд сурталчилгааг орон нутгийн BBS телевизээр давхардсан тоогоор 10 удаа, МҮОНТ-ийн орон нутаг дахь салбар INFO 6 удаа, аймгийн ЗДТГ, БОАЖГ-ын веб сайт пэйж FB хуудаст 15 удаа мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэж нийт 76800 хүний хандалтыг авч сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Танхимын болон цахим сургалтад 225 хүн хамрагдсан байна.	100%
82	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	1.3. Архи, согтууруулах ундаанд ногдуулах онцгой албан татварын орлогоос хавдрын эмнэлэг, донтох өвчнийг эмчлэх төв болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг байгуулах, архи согтууруулах ундааны хор уршгийг нийгэмд сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх чиглэлд зарцуулах;	Архи согтууруулах ундааны хор уршгийг олон нийтэд түгээх, хорт зуршлаас сэргийлэх чиглэлээр байгууллагын веб хуудас болон бусад олон нийтийн сүлжээгээр зөвлөгөө зөвлөмжийг түгээн ажиллаж байна. "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн төлөө хамтдаа" аяныг өрнүүлэн аяны хүрээнд Эрт илрүүлгийн үзлэгийн ач холбогдол, архи тамхины хэрэглээний хор уршиг, дасгал хөдөлгөөн, зохистой хооллолтын чиглэлээр 75 удаагийн сургалтыг 2860 хүнд хийсэн. " Зөв хэвшил- Зөв амьдрал" аяны хүрээнд 3 байгууллагын 62 ажилчин албан хаагчдад " Архи, тамхины хортой хэрэглээ" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Хүүхэд, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр 42 сургалт, нөлөөллийн ажил арга хэмжээ зохион байгуулсан ба цахим сургалт 34, аян 3, подкаст 4, контент нэвтрүүлэг 15, бэлтгэн 6425 хүүхэд залуучуудыг хамруулж, иргэд, олон нийтэд сурталчиллаа. "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ"-ээр 13 суманд ажиллаж архи согтууруулах ундааны хор уршгийн чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд 6359 хүүхэд, 3247 эцэг хамрууллаа. Хавсралт : 2 зураг	70%

83	1.4. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох;	Сүхбаатар аймгийн хэмжээний олон дагагчтай зар, мэдээ, мэдээллийн 12 группийн 36700 орчим гишүүдтэй цахим хуудаснуудад Монгол Улсын ерөнхийлөгчийн 2022 оны 43 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах чиглэлээр мэдээлэл өгч ажилласан. Мөн багийн засаг дарга, зохион байгуулагч нар хариуцсан хэсгийн байцаагч нартай хамтран “Шилдэг баг” шалгаруулах болзолт уралдааны гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх заалтын хэрэгжилтийг хангаж хариуцсан багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн 97, орон нутгийн өмчит 11, хувийн хэвшлийн 92 байгууллагын 1500 орчим ажилтан, алба хаагчдад архины хор хөнөөл, хэрхэн татгалзах, архигүй ажлын байр сэдвээр сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Төсвийн хэмнэлтийн тухай хууль болон бусад тогтоол шийдвэрийн хүрээнд шинэ оны баярыг төрийн байгууллагууд тэмдэглээгүй. Тус шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиглэлийг сумдын ЗДТГ болон аймгийн Цагдаагийн газарт хүргүүлж, иргэдэд мэдээ мэдээлэл өгч, хяналт тавин ажилласан.	100%
84	1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах;	Аймгийн Засаг даргын 2021 оны А/216 захирамжийн дагуу “Өсвөрийн шигшээ баг”-ийн спортын хэрэглэл, материалын шинэчлэлд 31,4 сая, тоглолтын хувцас шинэчлэлд 3,6 сая, нийт 34,4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2022 онд тамирчдын урамшуулал, тэмцээн уралдааны зардал, спортын хувцас, хэрэгсэл, материалын шинэчлэлд нийт 62,4 сая төгрөг зарцуулсан. МУ-ын СМ Ш. Энх-Амарын нэрэмжит Уулын дугуйн УАШ тэмцээн, Боксын спортын ОУХМ Н.Ганхуягийн нэрэмжит боксын олон хотын нээлттэй тэмцээн, Зүүн бүсийн аварга шалгаруулах насанд хүрэгчдийн болон өсвөр үеийн хөл бөмбөгийн 2 тэмцээн, Өсвөрийн жүдо бөхийн тамирчдын хамтарсан бэлтгэл, тэмцээн, Ахмад-22, нийт улс бүс, орон нутгийн чанартай 6 тэмцээн зохион байгуулахад 25,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Фитнес, аэробик, спенинг, иог чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Ханан" фитнес клубт түрээсийн хөнгөлөлт үзүүлсэн.	100%

85		2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай.	Тус аймгийн цагдаагийн газраас архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр төлөвлөгөө удирдамж гарган согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, архи согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээтэй холбоотой нөхцөл байдалд криминологи судалгаа хийж, архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, стандартын шаардлага хангахгүй газрын үйл ажиллагааг зогсоох, архи зардаггүй, үйлчилдэггүй өдөр цагийг нэмэгдүүлэх, архины хамааралтай иргэдийг оношлох, эмчлэх, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулах зэрэг арга хэмжээг аймаг, сумдын төр захиргааны болон төрийн бус байгууллагууд, иргэд олон нийтийн хүч оролцоотой хамтран хэрэгжүүлж байна. 2022 онд “Согтуу”, “Гудамж хяналт”, “Сар шинэ” “Субъектийн судалгаа”, “Объектын судалгаа” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж, аймаг, сумдын ЗДТГ болон аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллалаа. Хүч нэмэгдүүлсэн эргүүл шалгалтыг 3 удаа зохион байгуулж алба хаагчдыг хуваарьт оруулан үзлэг шалгалт хийж санамж, зөвлөмж өгч ажилласан. Арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор 150 албан хаагчид хяналт шалгалт хийж ажиллан, 276 байгууллага, аж ахуйн нэгж, 310 иргэнийг шалгаж ажилласан. Тус аймагт согтууруулах ундаанаас сайн дураараа татгалзаж, түүний хор хөнөөлийн эсрэг нэгдсэн “Мандах наран”, “Зөв боломж” АА-ын төрийн бус байгууллагатай хамтран гудамж талбай олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явдаг, архины хамаарал бүхий иргэдийг сар бүр архинаас татгалзах чиглэлээр сургалтад хамруулах ажлыг хамтран зохион байгуулж ажилласан одоогоор эдгээр иргэдээс 6 иргэн архинаас татгалзсан үр дүн гарсан байна.	100%
----	--	---	---	------

86	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159	2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай.	2022-2023 оны хичээлийн жилийн 09 дүгээр сарын 01-ний өдөр Монгол Улсын ерөнхийлөгчийн 2022 оны №159 тоот зарлигийг аймаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, аймаг сумын Засаг дарга, ИТХ-ын төлөөлөгч нар төр төлөөлөн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн хичээлийн шинэ жилийн нээлтэд дээр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай зарлигийг танилцуулан байгууллага бүрийн хүндэтгэлийн самбарт байршуулан залсан. Сүхбаатар аймгийн хэмжээнд 24 цэцэрлэг, 16 сургууль Чингис хааны эш хөргийг хүндэтгэлтэйгээр залж байршууллаа. Хавсралт : 3 зураг	100%
87		3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай.	Эзэн богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн дээдэлж, хүндэтгэн залах, суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахих талаар олон нийтэд сурталчлах, иргэн бүрд мэдээллийг нээлттэй, хүртээмжтэй мэдээлэх зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, Sukhbaatar.gov.mn сайт, Засаг даргын тамгын газар facebook хуудсаар дамжуулан мэдээллийг хүргэж ажиллаа. Мөн Аймгийн хэмжээний 16 сургууль, 24 цэцэрлэг, бусад төрийн болон төрийн бус байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэлтэйгээр эрхэмлэн заллаа.	100%
88		4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай.	Эзэн богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн дээдэлж, хүндэтгэн залах, суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахих талаар олон нийтэд сурталчлах, иргэн бүрд мэдээллийг нээлттэй, хүртээмжтэй мэдээлэх зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, Sukhbaatar.gov.mn сайт, Засаг даргын тамгын газар facebook хуудсаар дамжуулан мэдээллийг хүргэж ажиллаа.	100%
ҮАБЗ-ийн зөвлөмж				

89	Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18 Дугаар 2010_10/09	1. Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх,	Аймгийн хэмжээнд ашиглахыг хориглосон Баруун-Урт сумын 1 дүгээр цэцэрлэг, 3 дугаар сургууль, Дарьганга сумын 150 хүүхдийн цэцэрлэг зэргийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дахин төлөвлөж хөрөнгийг шийдүүлж шинэ барилга барьж ашиглалтад оруулж, эхлүүлсэн байна. Үүний зэрэгцээ эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэрлэх чанарыг тогтоохоор орон нутгийн төсвөөр 60,0 төсөвлөж ажлыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	70%
90		3. Газар хөдлөлтийн аюул, гамшигтай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг улсын хэмжээнд байнга, тогтмол давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооцдог байх,	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолын хүрээнд, 2011 оны 339, 340, 2016 оны 282 дугаар тогтоолууд, 2022 оны “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах, дадлага сургуулилтын өдөрлөгийн удирдамж”-ыг тус тус үндэслэн иргэд, олон нийтийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангуулах, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах Орон нутгийн ерөнхий зориулалтай мэргэжлийн ангийн нийт 858 хүн, Төрийн болон төрийн бус 70 байгууллагын 6617 хүн, 45 хувийн байгууллагын 3820 хүн нэгдсэн дадлага сургуулилтад нийт 10437 иргэн 70 автомашин техник хамрагдсан. Хавсралт : 4 зураг	100%

91	Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай 2017-01-10 Дугаар 2017_03/03	3.1. Аймаг, нийслэлийн ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн орчны бохирдлын асуудлыг хэлэлцэн холбогдох арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	2022 оныг "Хогийг мөнгө, Модыг төгөл болгоё" уриалга дэвшүүлэн төлөвлөгөө батлуулан ажилласан. Үүний үр дүнд аймгийн хэмжээнд 8 сумын 102,5 га газрын төвлөрсөн хогийн цэгийг тохижуулсан. Үүнээс 2 сум /Баяндэлгэр, Түмэнцогт/ стандартын шаардлагад нийцүүлэн 11 га газарт ландфилл 190 сая, 6 сум 91.5 га газрын нэгдсэн хогийг түрж далан үүсгэхэд 31 сая, мөн 4 сум /Баруун-Урт, Мөнххаан, Асгат, халзан/ хог тээврийн зориулалтын авто машин 3, ковш 2 нийт 5 техникийг худалдан авахад 371,2 сая төг зарцуулсан байна. Бүх нийтийн нэгдсэн цэвэрлэгээг улиралд 1 удаа нийт 32 удаа зохион байгуулахад 3459 өрх, 287 ААНБ хамрагдаж 645 тн хог хаягдлыг цэвэрлэж /400 гаруй сэг зэм, 16 машины кабин/, шинээр 23 ш ангилан ялгадаг хогийн сав байршуулан ажиллалаа. Дээрх ажил нийт 10 сая төгрөг зарцуулсан. - Шинийн найманд Шилийн богд, Алтан овоог зорин ирж буй жуулчдад байгаль дэлхийдээ ээлтэй, уул овоондоо хүндэтгэлтэй, хоггүй цэвэрхэн шинэлэхийг уриалсан 1500 ш гарын авлага, зөвлөмж, 400 ш хогийн уут тараагдсан ба аймгийн хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр нийт 530,2 сая зарцуулагдсан байна. Дээрх ажлуудыг хийхэд БХНСАХЗ - 20 сая, орон нутгийн төсвөөс 510,2 сая зарцуулагдсан байна.	100%
92	Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40	2.4. Томоохон голууд дээр усыг хуримтлуулан урсацын тохируулга хийх. усан сан байгуулах, нийт нутгийн хэмжээнд хур тундасны усыг тогтоон барих далан, шингээх худаг, нэвчүүлэн цөөрөм барих ажлыг эрчимжүүлэх замаар усны нөөцийгш нэмэгдүүлж,и хүн ам болон эдийн засгийн салбаруудыг баталгаатай, хүрэлцээтэй усаар хангах нөхцөлийг бүрдүүлэх	Сүхбаатар аймгийн хэмжээнд байгаа томоохон нуур болох Ганга нуурын усны нөөцийг сэргээх үүднээс газрын доорх усаар гадаргын усыг тэжээх замаар гидрогеологийн 3 цооног гаргасан. Мөн Ганга нуурыг малын хөлөөс чөлөөлөх үүднээс бэлчээрийн усалгааны зориулалттай 10 худаг, ногоон байгууламжийн усалгаа - 3 худаг тус тус гаргасан.	70%

93	2.6. УБ хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гэр хороолол, аймаг сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслөөр Баруун-Урт суманд баригдаж буй төв цэвэрлэх байгууламжийн нь 8.8 тэр бум төгрөгөөр баригдан аймгийн төвд хоногт 3000м3 бохир ус биологийн аргаар цэвэрлэх байгууламж баригдаж дууссан. БШУЯ-ны сайдын 2020 оны А/159 тоот тушаалаар Эрдэнэт үйлдвэрийн дэмжлэгтэй хэрэгжүүлж буй сургууль, цэцэрлэг, дотуур байрын нүхэн жорлонг орчин үеийн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар солих ажлын хүрээнд Эрдэнэцагаан, Наран, Халзан сумдын сургууль, дотуур байрын барилгуудын ариун цэврийн байгууламжийг байнгын ашиглалтад оруулах Улсын комисс ажиллаж 2022 оны 09 дүгээр сард ашиглалтад хүлээж авч 100% ашиглалтад орсон. Хавсралт : 3 зураг	100%
94	2.7. Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвлүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих	Усны тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу дахин ашигласан усны хэмжээгээр усны нөөц ашигласны төлөбрөөс чөлөөлөгддөг. Цайртминерал, Монголжүаньли, Каскэйд майнинг ХХК-уудын баяжуулах үйлдвэрүүд усыг 70-90 хувиар дахин ашиглаж байна.	70%

95		2.11. Хо, суурин газрын үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах системийн найдвартай ажиллагааг хангах	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд туссаны дагуу Баруун-Урт сумын төвд үерийн ус зайлуулах ил болон далд далан хийгдсэн. Байгалийн гэнэтийн гамшигт үзэгдэл болох үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, хүний амь насыг хамгаалах зорилгоор хатуу хучилттай авто зам дагуух үерийн далан, ус зайлуулах системийн аюулгүй ажиллагаанд хяналт тавин төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байна. Хот суурин газрын үерийн далангийн ус зайлуулах хоолойгоор ус чөлөөтэй урсах нөхцөл бүрдүүлэхийг холбогдох мэргэжлийн байгууллагуудад чиглэл өгч ажилласан. Эзэнгүй үүссэн хур хог хаягдлыг Сүхбаатар Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-ын ажилчид түүж цэвэрлэн аюулгүй ажиллагааг хангаж байна. 2022 онд нийт 300 тонн хог хаягдлыг зөөж тээвэрлэсэн. Энэхүү даланг цаашид өргөтгөх, шинэчлэх засвар үйлчилгээ хийх шаардлага үүсч байгаа бөгөөд орон нутгийн төсөвт санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр хүсэлтийг АИТХуралд 2023 оны ОНТөсөвт суулгуулахаар уламжилсан. Энэ онд хэрэгжиж байгаа 3-н сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд үерийн далан сувгийг нарийн тооцоо судалгаа хийж төлөвлөх чиглэлээр даалгаварт туссан болно. Хавсралт : 2 зураг	70%
----	--	---	---	-----

96	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар 2021_03	3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах.	Аймгийн хэмжээнд Зөвлөгөөн-1, Сургалт- 15, 17 төрлийн гарын авлага - 4100, ном -100 ш, мэдээллийн самбар- 11ш, Шторк-2 төрөл, 10 стекер хийсэн бөгөөд сурталчилгааг орон нутгийн BBS телевиз давхардсан тоогоор 10 удаа, МҮОНТ-ийн орон нутаг дахь салбар INFO 6 удаа, байгууллагын веб сайт пэйж FB хуудас 15 удаа мэдээллийг бэлтгэн олон нийтэд хүргэж нийт 76800 хүний хандалтыг авч сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Танхимын болон цахим сургалтад 225 хүн хамрагдсан байна. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар 16 сургууль ,24 цэцэрлэгийн албан хаагчдад болон иргэд олон нийтэд байгууллагын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан байгаль орчноо хайрлан хамгаалах соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан. Уг мэдээллүүдийг салбарын хэмжээнд үүрэг өгч олон нийтэд түгээсэн нь давхардсан тоогоор 30,000 хүнд хүрсэн.	70%
ЗГ-ын тогтоол				
97	"Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээг батлах тухай 2021-06-01 Дугаар 2021_161	3. "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээний хүрээнд сумдын Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулж ажиллахыг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.	Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор 4 сумын 3-т нь зураг төсвийн шатанд ахиц гарсан. -Мөнххаан сумын төвийн инженерийн шугам сүлжээг шинээр боловсруулагдаж байгаа Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шугам сүлжээний ажлын зураг боловсруулах ажлыг гүйцэтгүүлэхээр мэргэжлийн зураг төслийн Эрчим төсөл ХХК-тай сумын Засаг дарга болон аймгийн Засаг дарга нар хамтран ажилласан байна. - Баяндэлгэр сумын зураг, төслийн ажлыг Барилга, хот байгуулалтын сайдын багцын хөрөнгөөр шийдвэрлэн ажлыг 100% гүйцэтгэсэн. -Харин Дарьганга сумын зураг төслийн ажлыг аймгийн Засаг дарга болон сумын Засаг дарга нар хамтран "Дөрвөн гүн" ХХК-аар зураг, төслийн хөрөнгийг дараа төлөх нөхцөлтэйгөөр гүйцэтгүүлж байна.	70%

98	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	5.2 Орон нутгийн Сүхбаатарын өнгө сонин, BBS телевизийн мэдээ болон бусад нэвтрүүлгийн нэрийг монгол бичгээр бичдэг болсон. 7 хоног тутамд хэвлэгдэн гардаг “Сүхбаатарын өнгө” сонинд “Үндэсний бичгийн булан” нээж 10 сарын турш нийт 400 мэдээлэл нийтэлсэн. 5. Аймгийн архивын тасаг Архивын ерөнхий газрын зөвшөөрлийн дагуу аймгийн Засаг даргын тамгын газар хэвлэмэл хуудсаа хэвлэж албан хэргээ монгол бичгээр хөтлөх туршилтыг ажлыг 2022 оны 11 дүгээр сард эхлүүлсэн. Аймгийн хэмжээнд нийт 16 агентлаг, байгууллага монгол бичгийн фонд суулгаж хэвлэмэл хуудастай болж албан хэргээ хос бичгээр бичих туршилтын ажлаа туршиж ,16 сургууль, 24 цэцэрлэгт CMs Ulaanbaatar, CMs Uрга, huree зэрэг программыг компьютерт суулган монгол бичгээр хослуулсан бичих бэлтгэлийг хангасан. 5.4 13 сумын хэлний бодлогын зөвлөл сургалтын хөтөлбөр төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн. 5.5 Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч 30 байгууллагаас 19 , 13 сумын төсөвт 78 байгууллагаас 53 байгууллага гадна хаягаа монгол бичгээр бичиж байрлуулсан. Нийт байгууллагын хаягжилтын хувь 65,5%, 2022 онд шинээр 79 аж ахуйн нэгж монгол бичгэн гэрлэн хаягийг шинээр хийж хэрэгжүүлсэн. Байгууллагын доторх өрөө тасалгааны хаяг, танилцуулга самбар, ажилчдын энгэрийн тэмдэг, өргөмжлөл талархлыг монгол бичгээр хэвлэдэг 24 байгууллага байна. Хавсралт : 3 зураг	100%
----	---	---	--	------

99	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06 Дугаар 2022_139	1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх” богино хугацааны сургалтыг олон улсын тэргүүлэх шинэ дэвшилтэт арга хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авахыг “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т болон Засгийн газрын холбогдох гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх сургалт одоогоор аймагт зохион байгуулагдаагүй. Удирдлагын академиас 2022 оны 4 дүгээр сард зохион байгуулсан “Алсын хараа-2050” сургалтад БОАЖГ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Халзан сумын ИТХ, Мөнххаан ЗДТГ, Боловсролын газар, ЗДТГ, Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар, АЗДТГ-ын зэрэг 8 албан хаагч цахимаар хамрагдан сертификат авсан.	70%
100	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_204	3. Дуудлагын автомашины зориулалтаар хуваарилан шилжүүлснээс бусад автомашиныг төрийн холбогдох байгууллагын зайлшгүй шаардлага, хэрэгцээг харгалзан эрэмбэлсний үндсэн дээр зарим хэсгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д заасан байгууллагад албан ажлын зориулалтаар хуваарилах, үлдэх хэсгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Орон нутгийн өмчит 142 хуулийн этгээдийн автомашины судалгааг гаргасан бөгөөд тус судалгаан дээр үндэслэн тухайн байгууллагын автомашины эвдрэл, гэмтэл, татвар зэргийг бүрэн төлүүлэх талаар холбогдох байгууллагад саналыг хүргүүлсэн. Судалгаагаар нийт 67 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлэх боломжтой гэж гарсан. Тухайн байгууллагуудын автомашиныг татан төвлөрүүлэх талаар аймгийн хэмжээний байгууллагуудын удирдлага нарт аймгийн Удирдах ажилтны зөвлөгөөний үеэр танилцуулж, хурлын тэмдэглэлд тусгасан. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан байгууллагуудаас гаргасан санал хүсэлтийг хүлээн авч байна. Одоогийн байдлаар дуудлагын худалдааг зохион байгуулах талаар холбогдох байгууллагын шийдвэр ирээгүй болно.	70%

101		9. Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.	Аймгийн ИТХ-ын ээлжит 11 -р хуралдаанаар буюу 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдөр "Сүхбаатар нийтлэг Үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дуудлагын авто машины үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг нэмж, тус үйл ажиллагааг хариуцуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан Сүхбаатар-Нийтлэг Үйлчилгээ ОНӨААТҮГ-т байгууллагын жолооч нарыг үргэлжлүүлэн, шилжүүлж ажиллуулахаар тусгасан ба шинэ төсвийн жилээс цалин хөлс, ажлын байр, албан тушаалыг шинэчлэн томилгоожуулж ажиллах шийдвэр гараад байна.	70%
102	Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-09 Дугаар 2022_402	1.3. цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон арга хэмжээ байхгүй.	100%
103		1.4. орон сууцны хороолол, цогцолбор барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэг байгуулах зорилгоор түрээслэх, худалдан авах, салбар бүлэг ажиллуулахад норм нормативыг мөрдүүлэх чиглэлээр мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг авч, хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Түмэнцогт суманд 24 айлын орон сууцны 1 давхарт байрлах 119 мкв бүхий 2 өрөө байранд цэцэрлэгийн салбар бүлэг ажиллаж байна. Салбар бүлэг нь багш ажилчдын ариун цэврийн өрөө, хүүхдийн ариун цэврийн өрөө / угаалтуур 3, суултуур-3/, хүүхэд хүлээн авах өрөөтэй. Сум хөгжлийн сангийн төсвөөр худалдан авсан, сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд данс бүртгэлтэй. 28-35 хүүхэд хүлээн авч СӨБ-ыг олгож байна. Энэ хичээлийн жилд 4 настай 30 хүүхэд суралцаж, бүлгийн багш, туслах багш ажиллаж байна.	100%

104	2. Цаашид шинээр баригдах орон сууцны хороолол, цогцолбор барилга байгууламжийн зураг төсөлд цэцэрлэг төлөвлөх, ашиглалтад оруулах талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллахыг дор дурдсан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай: 2.1. барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг заавал тусган баталгаажуулж байхад хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 2.2. орон сууцны хороолол, цогцолбор барилгад төлөвлөгдсөн цэцэрлэгийн барилгыг бүрэн ашиглалтад орох хүртэл хугацаанд тухайн бүс нутгийн байршилд “түр цэцэрлэг” байгуулан ажиллуулж байх талаар хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд хэрэгжиж буй 960 айлын орон сууцны барилгын инженерийн шугам сүлжээний ажлыг тухайн газар нутгийн онцлогт тохируулан судалгаа шинжилгээ хийн (№3Д-019/2022) зургийн даалгаврыг боловсруулан холбогдох мэргэжилтнүүдээр хянуулан Аймгийн Засаг дарга баталсан . Зураг төслийг “Сивил инженеринг консалтинг” ХХК СИК-06/2022 шрифтэй зураг төсөв боловсруулан. “Төсөвт төсөл”ХХК түлхүүр гардуулах нөхцөлтэй шугаман, сүлжээ барилга угсралтын ажлыг эхэлсэн. 2022 онд Ажлын зураг төсөл бүрэн хийгдэж магадлалаар баталгаажсан. Барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг тусган баталгаажуулсан.	100%
105	3. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусгасан эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Тус аймгийн Халзан, Мөнххаан, Сүхбаатар сумдад хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаа болно. Тус төлөвлөгөөний зургийн даалгаварт одоо ашиглаж байгаа цэцэрлэг, сургуулийн барилгын хүртээмжид нарийн судалгаа хийж цаашид өргөтгөл шинэчлэлийн ажлыг хийх талаар төлөвлөгөөнд тусгаж төлөвлөх зэрэгт хяналт тавьж байна.	100%
106	4. Цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр түрээслэх, худалдан авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх, шаардагдах зардлыг жил бүрийн улс, нийслэл, орон нутгийн төсвийн төсөлд тусгахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Аймгийн төвд шинэ суурьшлын бүсэд Баруун-Урт суманд 900 айлын хороолол төлөвлөгдөж , инженерийн шугам сүлжээний ажил хийгдэж байна. Түмэнцогт суманд 24 айлын орон сууцны 1 давхарт цэцэрлэгийн бүлэг байгуулан 25 хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгож байна.	70%

107	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419	3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай./	Аймгийн Засаг даргын 2022 оны захирамжаар аймгийн хот, хөдөөгийн сэргэлтийн дэд ажлын хэсгийг байгуулаад байна. Ажлын хэсэг 2023-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлаар "Нээлттэй Сүхбаатар хөтөлбөр батлуулсан ба аймгийн 2023 оны төсөвт үйл ажиллагаанд шаардагдах төсөв болох 10950,0 сая төгрөгийг батлуулсан. Тус аймгийг ХХААХҮ-ийн дэд сайд хариуцан ажиллаж байна.	100%
108		4. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Аймгийн Засаг даргын 2022 оны захирамжаар аймгийн хот, хөдөөгийн сэргэлтийн дэд ажлын хэсгийг байгуулаад байна. Ажлын хэсэг 2023-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлаар "Нээлттэй Сүхбаатар хөтөлбөр батлуулсан ба аймгийн 2023 оны төсөвт үйл ажиллагаанд шаардагдах төсөв болох 10950,0 сая төгрөгийг батлуулсан. Тус аймгийг ХХААХҮ-ийн дэд сайд хариуцан ажиллаж байна. Аймгийн хүн амыг 10 хувиар нэмэгдүүлэх зорилгоор аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар нээлттэй Сүхбаатар хөтөлбөр боловсруулан батлуулсан	100%

109	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448	1.12. . 1.12 гүйцэтгэсэн ажлын бүтээмжийг нь харгалзан аймаг, сумын засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг хоёр дахин хүртэл нэмэгдүүлсэн хэмжээгээр тооцож, орон нутгийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан олгох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.13.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.14.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.15.нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд жилийн 3 хувийн хүүтэй ипотекийн зээл олгох, орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжийн арилжааны банкнаас авсан зээлийн хүүг 1 хувь хүртэл бууруулж олгох ажилд орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.16.нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнесээ эрхлэхэд нь зориулж	Орон нутгийн төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар нэмэгдүүлэн олгох асуудлыг Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн 2023 оны төсөвт төсөвлөсөн. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллаж байна.	100%
-----	--	--	---	------

		газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгох арга хэмжээг хүнд сурталгүйгээр шуурхай шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.17.гадаад зээлийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Монгол Улсын 2023 оны төсөвт тусгасан дүнгээр бүрэн төлж барагдуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;		
--	--	--	--	--

110	2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах.	Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит хуралдаанаар аймгийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний санал, тайлбарыг АИТХ-д өргөн мэдүүлж 2023 оны төсвөө батлуулсан. 2023 оны төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр 40 арга хэмжээ, 2023 оны төсвийн жилд санхүүжих 15365,4 сая.төгрөг / шилжих 15 ТАХ- 4346,4 сая,төгрөг, шинээр хэрэгжих 25 ТАХ төсөвт өртөг 14044,0 сая.төгрөг, 2023 онд санхүүжих 11019,0 сая.төгрөг/ Удирдлагыг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээгээр 20 төсөл арга хэмжээ, 2022 онд санхүүжи хдүн 3186,6 сая төгрөг батлагдсан. Үүнээс шинээр хэрэгжих 18 ТАХ төсөл арга хэмжээ төсөвт өртөг 4480,9 сая.төгрөг, 2023 онд санхүүжих дүн 3005,9 сая.төгрөг Их завсарын зардлаар 12 ТАХ, санхүүжих дүн 1349,0 сая.төгрөг үүнээс шинээр хэрэгжих 9 ТАХ, төсөвт өртөг 1214,2 сая.төгрөг, 2023 онд санхүүжих дүн 1168,2 сая.төгрөг Автозамын сангийн сангийн хөрөнгөөр 3 ТАХ, төсөвт өртөг 810,0 сая.төгрөг, 2023 онд санхүүжих дүн нь 810,0 сая.төгрөг тус тус батлагдсан. УТХО-аар эрх шилжин хэрэгжиж байгаа 25 төсөл арга хэмжээ Үүнээс: шинээр хэрэгжих 13 төсөл арга хэмжээ, төсөвт өртөг 31212,5 сая.төгрөг, 2022 онд санхүүжих дүн 11788,7, шилжих хөрөнгө оруулалт 12 төсөл арга хэмжээ, төсөвт өртөг 27436,0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 10518,3 сая.төгрөг. УТХО 100 хувь цахим системд шилжсэн бөгөөд гүйцэтгэлийн мэдээллийг тухай бүр цахим системд оруулж, санхүүжилтийг тухай бүр гүйцэтгэгч компанид олгож байна. 10 сарын 1-ээс санхүүжилт 100 хувь цахимд шилжиж сангийн яамнаас фортал системээр дамжин гүйцэтгэгчийн дансанд шууд олгогдож байна.	100%
-----	--	---	------

ЗГ-ын хуралдааны тэмдэглэл				
111	2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр 63 дугаар тэмдэглэл 2021-12-08 Дугаар 2021_63	ХҮ.3.1.3. Орон нутгийн түвшинд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн шалтгааныг судалж, холбогдох зохицуулалт, арга хэмжээ авахад санаачилга гарган ажиллахыг бүх аймгийн засаг дарга нарт;	Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хугацаа, гарал үүслийн талаарх мэдээлэл, үйлчилгээний үнийн өсөлтийн шалтгааныг судалж, нэр төрлөөр нь ангилж бөөний төвын 7 цэг, 21 хүнсний дэлгүүрт ШӨХТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу ШӨХТГ-ын орон нутаг дахь улсын байцаагч хяналт шалгалт хийж ажиллалаа. Хяналт шалгалтаар бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх түүхий эд нэмэгдсэн нь нийлүүлэлтээр ирж байгаа өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдсэнтэй шууд хамааралтай байна. Мөн улсын хэмжээнд бензин үнэ өссөнтэй холбоотойгоор тээврийн зардал нэмэгдэж өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдсэн байна. Цаашид өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг тогтмол судалж аж ахуй нэгж албан газруудын захирал, эрхлэгч нартай холбоотой ажиллаж байна. Аймгийн төвд мах, махан бүтээгдэхүүн худалдан борлуулж буй 2 захын худалдагч нартай уулзалт зохион байгуулж махны үнийг одоогийн зах зээлийн ханшнаас нэмэгдүүлэхгүй байх, үнийг тогтвортой байлгах чиглэлээр тохиролцоонд хүрч ажиллаж байна.	70%

112	2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2022-03-02 Дугаар 2022_14	ХИҮ.7.7. Нийлүүлэлт нь хүндэрч болзошгүй бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангахад шаардлагатай тээвэр, логистикийн зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	"Номин бизнес клуб Зүүн бүс" ХХК нь "Номин" сүлжээ дэлгүүрийн 21 аймгийн Сүхбаатар аймаг дахь салбар дэлгүүр бөгөөд тээвэр логистикийн хувьд тендер зарлан 3-4 компанийг шалгаруулж 21 аймаг руу ээлжлэн барааг нийлүүлэлддэг ба ковид цар тахлын үеэр хэвийн ажиллаж бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт таслалдаагүй байна. Тус компаний бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт тогтвортой явагддаг сард тогтмол 7 удаагийн 280 тн бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт татан авалтыг хийсэн ба 7 хоногт 40 тн барааг Улаанбаатар хотоос нийлүүлдэг, баяр ёслолын өдрүүдэд ачаалал ихсэж 7 хоногт 80 тн барааг татаж авдаг. "Сүхбаатар Жавхлант Улз" хүнсний дэлгүүрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт тогтвортой ба тээвэрлэлтийн хувьд "Сүхбаатар Жинчин" ХХК-тай байнгын гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд 7 хоногт 25 тн, сард 100 тн барааг гэрээний дагуу татан авдаг. Өсөх дэлгэрэх ундрах ХХК-ийн Ундрах супер маркет 7 хоногт 2-3 удаа тогтмол 80-100 тн барааг Улаанбаатар хотоос татан төвлөрүүлдэг ба тээвэрлэлтийн хувьд 3 том ачаа тээврийн машинтай байнгын гэрээ хийсэн.	100%
-----	---	---	--	------

113	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	ХХ.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.	Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн дагуу орон нутагт 2022 оны байдлаар нийт 16 аж ахуй нэгж, 4918 иргэнд улсын бүртгэлийн хэлтсээр дамжуулан тоон гарын үсгийн олголтыг хийгээд байна. Аймгийн хэмжээнд нийт 24 төрийн байгууллагын гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан тоон гарын үсгийг авч үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 13 сумын үйлчилгээний операторуудад МОНПАСС СА ххк-аас 374,000 үнэ бүхий тээгч төхөөрөмж болон 1 жилийн эрхтэй тоон гарын үсгийг гэрчилгээг олгож ажилласан. Тоон гарын үсгийг хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс сумдын тамгын газрыг monpass.mn системд бүртгүүлэн тоон гарын үсгийг захиалах боломжийг бүрдүүлж өгсөн. Сумдын операторуудад тухайн тоон гарын үсгийн системээр дамжуулан захиалга хийх, нэхэмжлэх үүсгэх, гэрээ, албан тоотыг татан авах зэрэг зөвлөгөө мэдээллийг өгч цахим сургалтыг хийлээ. Байгууллагын хэмжээнд нийт 50 албан хаагчдад МОНПАСС ХХК-ийн токен төхөөрөмжийг худалдан авч Үндэсний Дата төвөөр 2 жилийн гэрчилгээг суулгуулж албан хэрэгцээндээ ашиглаж байна. Төхөөрөмжийн зардалд нийт 1,144,000 төгрөгийг ЗДҮАХ-ийн зардлаас шийдвэрлүүлж ажилласан.	100%
-----	---	---	---	------

114	2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар 2022_33	XIII.1. . Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хяналт тавих, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг зохих журмын дагуу дэмжиж ажиллах; 1.2. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хамгаалах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт тавьж ажиллах.	1.1 2022 оны 05 дугаар сард орон тооны бус салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, холбогдох асуудлыг хэлэлцэв. Мөн салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, ХБИргэдийг эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, санал санаачлагыг дэмжих хүрээнд аймгийн Засаг даргын нөөц сангаас 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэв. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хоцрогдлыг эрт илрүүлэх, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор Аймгийн Засаг даргын 2022 оны А221 дүгээр захирамжийн хүрээнд салбар коимсс 2022 оны 04, 10 дугаар саруудад аймгийн 11 суманд ажиллаж, удирдамжийн хүрээнд холбогдох ажлуудыг зохион байгууллаа. 1.2 . Тайлант хугацаанд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг сурталчлах сургалтыг 3 удаа зохион байгуулаад байна. Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг аймгийн 13 сумдад ажиллаж, уулзалт зохион байгуулж, ХБИргэдийн талаарх сургалт, нөлөөллийн арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас 3500.0 мянган төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн байна. 1.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлж буй эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран "Цацарсан хайр - Цалгисан итгэл" өдөрлөг арга хэмжээг 2022 оны 04-р сард Баруун-Урт суманд зохион байгуулж, 50 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эхийг хамруулав.	100%
-----	--	--	--	------

115	XIII.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, хөгжлийн үйлчилгээг сайжруулахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 4.1. байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч, ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа эцэг, эсхүл эх, хууль ёсны асран хамгаалагчийн эрүүл мэндийн даатгалын болон тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож улсын төсвөөс төлөх боломжийг судлан саналаа шаардагдах зардлын тооцооллын хамт танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.2. Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр болон эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмжийн хэмжээг 288,000 төгрөгөөр үргэлжлүүлэн олгох болон цаашид уг хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх боломжтой эсэхийг судалж, зохих арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт; 4.3. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд шаардлагатай хүний нөөцийн судалгааг хийж, дутагдалтай байгаа мэргэжилтнийг 2022-2023 оны хичээлийн	ХНХС, БШУС, ЭМС-ын хамтарсан А/220, А/475, А/812 дугаар тушаалын дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал”-ын анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд 9,18, 36 сартай 275 хүүхдүүдийг эрт ирүүлэгийн үзлэгт хамруулж, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 5 хүүхдийг нарийн үзлэг хийлгэж, асуудлыг шийдвэрлүүлсэн. АНЭ-ийн эмнэлгийн сэргээн засах эмчилгээний тасагт хөгжлийн бэрхшээлтэй 116 иргэн хамрагдаж амбулаториор сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд "Хашчулуун энхийн цэцэг" ТББ, "Озон сервис" ТББайгууллагуудтай хамтран 140 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах үйлчилгээг үзүүлээд байна. Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эцэг эхийн холбоо “Эрхэм ертөнц” ТББ-ын тогтмол үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангах зорилгоор аймгийн ГБХЗХГазарт тогтмол өрөөгөөр хангахаар болоод байна. Мөн аймгийн Засаг даргын зүгээс тус холбоог NOTEBOOK-ээр хангалаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хоцрогдлыг эрт илрүүлэх, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор Аймгийн Засаг даргын 2022 оны А221 дүгээр захирамжийн хүрээнд салбар комисс 2022 оны 04, 10 дугаар саруудад аймгийн 11 суманд ажиллаж, удирдамжийн хүрээнд холбогдох ажлуудыг зохион байгуулав.	70%
-----	---	--	-----

	жилээс эхлэн үе шаттайгаар бэлтгэх, сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.4. хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтний урамшууллыг нэмэгдүүлэх асуудлыг судалж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.5. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийг хүүхдээ асрах, хөгжүүлэх, дэмжих чиглэлийн богино хугацааны сургалтад хамруулж, энэ чиглэлээр хөдөлмөр эрхлэх, цаашид мэргэжил эзэмшихэд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.6. хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийг үнэлэх Үйлдлийн олон улсын ангилал (ICF)-ыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.7. эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчгүй, байнгын асаргаа шаардлагатай сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн асрамжийн газрыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэд байгуулах асуудлыг судалж, шаардагдах	
--	--	--

	санхүүжилтийг Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.8. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн эрүүл мэнд, сэргээн заслын цогц тусламж, үйлчилгээг өргөжүүлж, мэргэжил, арга зүй, хүний нөөц, эм хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, үйл ажиллагааны чанар, үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.9. харьяалах нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэндийн болон нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлдэг, тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт, 4.10. бага орлоготой, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн гишүүнтэй өрхийн орон сууцны хангамж, нөхцөлийг судлан сайжруулах шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	
--	---	--

116	2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42	ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Аймгийн Нэгдсэн эмнэлгийг түшиглэн Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулан их засвар, тоног төхөөрөмжид нийт 1.1 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэн 2022 оны 5 дугаар сараас эхлэн бүх насны иргэдийг нас, хүйс, эрүүл мэндийн байдалд буурилсан халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан АНЭ-т дэмжлэгт хяналтыг 2 удаа хийж зөвлөмж чиглэл өгсөн.Албан байгууллагуудыг хуваарийн дагуу үзлэг, шинжилгээнд хамруулсан ажиллаж байна. 11 сарын байдлаар үзлэгийн хамрагдалт 11.3 хувьтай байна.Алслагдсан, хүн амь олонтой Эрдэнэцагаан, Баяндэлгэр, Уулбаян, Мөнххаан сумдад"Эрүүл Сүхбаатарчууд" төслийг хэрэгжүүлэн эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэдийг үзлэг шинжилгээнд хамруулах зорилгоор үзлэг , оношлуурын зардалд ОНТ-өөс 38 сая төгрөгийг шийдвэрлэн 1000 гаруй иргэдийг явуулын үзлэг оношилгоонд хамруулах арга хэмжээг хэрэгжүүллээ.	100%
117	2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54	Х.11.2. “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг байгууллагын үйл ажиллагаанд уялдуулан зохион байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллахыг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч нарт;	Аймгийн хэмжээнд “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-д Сүхбаатар аймгийн Шүүх, Прокурор, Цагдаагийн газар бүрэн хэрэгжиж байна. “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг байгууллагын үйл ажиллагаанд уялдуулан зохион байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллахыг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг ажиллах нөхцөл боломжоор хангаж ажиллах чиглэлээр анхаарч судалгааны түвшинд ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар энэхүү программын чиглэл ирээгүй болно.	70%

118		Х.12.2. “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж төрийн өмчийн бүх шатны боловсролын сургалтын байгууллагын болон шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч, дүнг танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Сүхбаатар аймгийн Засаг даргын 2016-04-27-ний өдрийн А/176 тоот захирамжаар 2500 м.кв газрыг албан конторын зориулалтаар эзэмших эрх авч 2018 оноос санхүүгийн тайланд 25 сая төгрөгөөр үнэлэн биет бус хөрөнгөөр бүртгэн , 0000090694 тоот газар эзэмших гэрчилгээний дагуу ашиглаж байна	100%
119	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.5. . Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан дүнгийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Отор нүүдлийн шилжилт, хөдөлгөөнийг мал эмнэлгийн үзлэгт хамрагдсан гарал үүслийн гэрчилгээг үндэслэх, тархвар зүйн асуумжийн дагуу зохион байгуулан ажиллах талаар аймаг, сумд хооронд гэрээ байгуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг бүх шатны Засаг дарга нарт;	2022-2023 онд аймгийн хэмжээгээр 13 сумын 67 багийн 8570 малчин өрхийн 4409.4 мянган толгой мал өвөлжиж, хаваржих урьдчилсан дүн гарсан. Үүнээс сум орон нутагтаа 6397 малчин өрхийн 3260.9 мянган толгой мал, өөрийн аймгийн өөр сумын нутагт 1273 өрхийн 694.7 мянган толгой мал, хилийн хориотой зурваст 397 өрхийн 243.5 мянган мал, тусгай хамгаалалттай бүс нутагт 480 өрхийн 195.1 мянган мал, Өөр аймгийн нутаг буюу Дорнод, Хэнтий, Дорноговь аймгийн нутагт 23 өрхийн 15.2 мянган мал тус тус өвөлжинө. Засгийн газрын 277 дугаар тогтоолын дагуу аймгийн аюулаас хамгаалах нөөцөд 550 тн өвс, 60 тн тэжээл, сумдын аюулаас хамгаалах нөөцөд 1058 тн өвс, 228 тн тэжээлийг сум бүр нөөцийнхөө агуулах, хашаанд нөөц бүрдүүлсэн. Малчид, иргэд 15416 тн өвс, 1445 тн ногоон тэжээл, 1710 тн үйлдвэрийн тэжээл, 365 тн гар тэжээл, 18068 тн давс, хужир шүү бэлтгэсэн.	100%

120		XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийг Сүхбаатар аймгийн хэмжээнд нийт 114 байгууллагад нэвтрүүлээд байгаа бөгөөд бусад дотоодын Ер системүүд рүү цахимаар бичиг, тоот илгээх ажлыг хийж хэрэгжүүлж байна. Тус арга хэмжээний хүрээнд албан бичиг солилцооны дундын системд өөрийн байгууллагын ашиглаж байгаа нэгдсэн системийг холбох заавар, чиглэлийг харьяа сум болон төрийн байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа.	100%
ЗГ-ын албан даалгавар				
121	Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай 2022-07-04 Дугаар 2022_3	2. Энэ албан даалгаврын 1-д заасан төлөвлөгөөнд тусгах нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамаарах төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө Цахим хөгжил, харилцаа холбооны яамны санал, зөвлөмжийг заавал авч байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1 -т заалт, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас 2022-03-04-ны 03/241 албан тоотод тусгагдсаны дагуу цахим аймаг хөтөлбөр боловсруулах зөвлөмжийн дагуу "Цахим Сүхбаатар" хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна. Цахим хөгжил харилцаа 13 сум, агентлаг, албадын цахим шилжилтийн хүрээнд хийж хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээнд урьдчилсан байдлаар үнэлгээ дүгнэлт хийж ажиллалаа.	70%
122	Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай 2022-07-05 Дугаар 2022_6	1. 1.1. ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2.""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах;	ХХААХҮ, ХЗДХ, Соёлын дэд сайд нар тус аймагт 12 сарын 27-ны өдөр ажиллаж "Нээлттэй Сүхбаатар аймаг" хөтөлбөр болон тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийн талаарх хэлэлцүүлгийг зохион байгуулах үеэр "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар бүх сумдын Засаг дарга, аймгийн ЗДТГ болон агентлаг, байгууллагын удирдлага, албан хаагчдад мэдээлэл өгсөн. Уг арга хэмжээнд 85 албан хаагч хамрагдаж Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын бичигт тусгагдсан зорилт арга хэмжээний талаарх мэдээллийг авлаа.	70%

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.МӨНХЦЭЦЭГ

ТАЙЛАНД ҮНЭЛГЭЭ ӨГСӨН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Т.ХУРЦБАЯР

ТАЙЛАНД ХЯНАСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН

ДАРГА

Д.БААСАНДОРЖ